

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН ЗАСГИЙН ГАЗАР 100 ХОНОГТ

/25.01.2006-05.05.2006/

Үндэсний Эв нэгдлийн Засгийн газар байгуулагдан үйл ажиллагаагаа эхлээд 100 хоног болж байна. Үндэсний Эв нэгдлийн Засгийн газар УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тэгэхдээ Засгийн газрын бүрэн эрхийн 2 жил гаруй хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Үндэсний Эв нэгдлийн Засгийн газар байгуулагдмагц шийдвэрлэгдээгүй, нийгэмд тулгамдсан иргэдийг бухимдуулсан зарим асуудлыг хугацаа алдахгүйгээр шийдвэрлэхийн зэрэгцээ Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд бодлогын чанартай асуудлуудыг иргэд, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллага, холбоодын саналыг тусган боловсруулж, дэс дараатай шийдвэрлэх арга хэмжээ авч байна.

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Монгол Улсын Ерөнхий сайд захирамж гаргаж, зарим сайд, аймгуудын Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан 14 журам, захирамжийг хууль тогтоомжид нийцээгүй үндэслэлээр хүчингүй болгосон бөгөөд цаашид улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй, нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн эрх зүйн үндэслэлийг Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан улсын бүртгэлд бүртгүүлж, олон нийтэд мэдээлсний дараа мөрдүүлж ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга нарт үүрэг өгч ажиллаж байна.

Төр нь иргэддээ нээлттэй байж, шуурхай үйлчилдэг болох зорилгоор төрийн байгууллагуудад нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх, хүнд сурталгүй үйлчлэх, хэрэгцээтэй мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Засгийн газраас авилгалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал, төрийн албан хаагчид авилгалд автахгүй байх тухай амлалт өгдөг журмыг тогтоох зорилгоор УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж, хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлээд байна.

“Яам болон аймаг нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг үнэлж дүгнэх журам”-ыг шинэчлэн батлав. Уг журамд яам, аймаг нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг үнэлэх үр дагаврын шалгуур үзүүлэлт, хэрэглэгчдийн үнэлгээг тусгахаар шинээр орууллаа.

Үндэсний эв нэгдлийн Засгийн газраас улс орон, ард түмний өмнө, ялангуяа орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх шаардлагын үүднээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцан, үндэсний эв нэгдлийн Засгийн газраас хийсэн эхний алхам, арга хэмжээг иргэдэд танилцуулж, тэдний санал бодлыг сонсож, шинэ Засгийн газрын бодлого, шийдвэрт тусгах зорилгоор Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд орон нутагт ажиллалаа.

Энэ Засгийн газраас иргэд ихийг хүлээж байна. Үүнийг зөв мэдэрч, чухамхүү тэдгээрийг бодитойгоор бүтээн буй болгох нь нэн чухал зорилт болж байгаа учраас ард иргэдийн амьдралд нэн тэргүүнд шаардлагатай байгаа асуудлыг шийдвэрлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн шинээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Засгийн газраас орон нутагт ажилласны мөрөөр авах арга хэмжээний хүрээнд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарын семинарыг зохион байгуулж, цаашдын зорилтыг тодорхойлж тэдэнд тодорхой үүрэг даалгавар өгч ажиллаж байна. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нарын сургалт, семинарыг зохион байгууллаа.


Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт

2006 оны батлагдсан улсын төсөв дээр төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэх, нийгмийн хамгааллын чиглэлээр 51.0 тэрбум төгрөгийг төсвийн тодотголын төсөлд тусгасан нь иргэдэд хүргэх нийгмийн үйлчилгээ өргөжин, төрийн албан хаагчдын нийгмийн байдлыг сайжруулахад томоохон алхам болсон юм.

- Төсвийн байгууллагад ажиллагсдын цалинг **30** хувиар нэмэгдүүллээ. Цалин, хөлсийг нэмэгдүүлснээр төрийн албан хаагчдын нийгмийн өмнө хүлээсэн үүрэг нэмэгдэж, ажлын харууцлага сайжрах болно. Нийгмийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд шинэчлэл гарч хүнд суртал, чирэгдлийг арилгахад нөлөөлнө. 124 мянга гаруй төрийн албан хаагч хамрагдсан ба сарын цалин дунджаар 115.0 мянган төгрөгт хүрч, өмнөх оныхоос 35 хувиар нэмэгдэж байна.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 53 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ



- Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 32.5 хувиар нэмэгдүүлж, 20480 төгрөгт хүргэв. Энэ арга хэмжээнд нэн ядуу амьдралтай 44.0 мянга гаруй иргэн хамрагдав.
- 1998 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь 120.0 мянган төгрөгөөр хязгаарлагдаж байсан 17.6 мянган иргэний тэтгэврийг шинэчлэн тогтоож, энэ арга хэмжээнд 1.9 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар тооцлоо.
- Мөн төсөвт байгууллагад гэрээгээр ажиллагсдын нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцах асуудлыг шийдвэрлээд байна.
- Шинээр мэндэлсэн хүүхэд бүрт 100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгохоор болж байгаа нь нэг талаар хүн амын өсөлтийг дэмжсэн, нөгөө талаас нялхсын эрүүл энх өсч бойжих, хэвийн орчинд хүмүүжих нөхцөл бүрдүүлэхэд төрийн зүгээс үзүүлж байгаа тусламж, дэмжлэгийн нэг хэлбэр юм.
- “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийн хүрээг өргөжүүлж, амьжиргааны түвшинг харгалзахгүйгээр бүх хүүхдэд **3000 төгрөг** олгохоор төсвийн тодотголын төсөлд тусгаад байна.
- Шинээр гэр бүл бологсдод 500.0 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлэхээр болж байгаа бол цаашид ажлын байраар хангах, орон сууцны зээл олгох, тэрчлэн гэр бүл салах, хүүхэд өнчрөх явдлыг багасгах асуудалд анхаарч байна.
- Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одонтой эхэд 100.0 мянга, 2 дугаар зэргийн одонтой эхэд 50.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж олгох асуудлыг боловсруулж зарцуулах хөрөнгийг төсвийн тодотголын төсөлд тусгалаа.
- Монгол Улсын болон хөдөлмөрийн баатар, алдар цолтон, дайнд оролцсон ахмад дайчдад улирал тутам олгодог мөнгөн тусламж **24750** төгрөг байгааг нэмэгдүүлж, **50** мянган төгрөгт хүргэхээр төсвийн тодотголын

төсөлд тусгаад байна. Ингэснээр нэг хүн жилд 200.0 мянган төгрөгийн тусламж авдаг болж, үүнд 3089 ахмад дайчин, алдар цолтон хамрагдана. Гавьяат цолтой ахмадуудад жилд нэг удаа удаа олгож байсан мөнгөн тусламжийн хэмжээг нэмэгдүүлж **100.0 мянган төгрөгт** хүргэхээр тооцоолж, нэмж шаардагдах хөрөнгийг төсвийн тодотголын төсөлд тусгаад байна. Шинэчлэн батлагдсан “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн дагуу төрийн соёрхолт, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн 157 ахмад настан энэ тусламжид шинээр хамрагдах бөгөөд нийт 693 ахмад настанд 36.9 сая төгрөг нэмж шаардагдана.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагад бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 32.6 мянга болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 4034 хүнээр, ажилгүйдлийн түвшин 3.3 хувь болж, 0.2 пунктээр тус тус буурчээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оны эхний саруудын байдлаар 617684.3 мянган төгрөгийн хөрөнгө төвлөрүүлснээс мэргэжлийн баримжаа олгох давтан сургах, нийтийг хамарсан, орон нутгийн шинж чанартай ажилд оролцуулах, ажил олгогчдыг дэмжих, жижиг зээл олгоход зарцуулж иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг зохион байгуулав.

НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхэд, залуучуудын хөгжлийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Өсвөр үе, залуучууд-хөгжилд” үндэсний чуулган зохион байгуулж, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэлэлцүүлэв.

- ✓ *Үндэсний чуулганаар даяарчлалын өнөө үед аж төрж буй, аливаа хорт зуршилгүй, эрүүл зан үйл бүхий бүтээлч, чадварлаг, ёс зүйтэй залуу үеийг дэмжин хөгжүүлэх, аюулгүй, амгалан тайван байдал тогтоох болон нийгмийн амьдралд идэвхтэй оролцогч болгон төлөвшүүлэх ээлтэй орчныг бүрдүүлэхэд залуу хүн бүрийн оролцоог хангах асуудлыг тал бүрээр хэлэлцэж, зөвшилцөв.*

Эрүүл мэндийн салбарт

“Иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төсөл, Рашаан сувиллыг хөгжүүлэх, Сэтгэцийн эрүүл мэнд, Осол гэмтэлтэй тэмцэх, Иод дутлын эмгэгтэй тэмцэх, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүд, Сумын эмнэлгийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайлан, Үндэсний Шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой журам, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр, санхүүжилт, хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлээд байна.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг батлуулав.

- ✓ *Хөтөлбөрийн хүрээнд хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа вируст гепатит, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, ДОХ зэрэг халдварт өвчин, зүрх судас, умайн хүзүүний хавдар, чихрийн шижин зэрэг халдварт бус өвчнийг бууруулж, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор өвчлөлийн түвшин тогтоох, үзлэгээр илэрсэн хүмүүсийг эмчилгээнд хамруулах, өвчлөлийн мэдээллийн сан байгуулах, эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа явуулахаар урьдчилан сэргийлэх үзлэгийг 15-аас дээш насны хүн амын дунд үзлэг хийх ба үүнд нарийн мэргэжлийн эмч нараас бүрдсэн гурван баг буюу 60 гаруй ажилтан ажиллаж, 6 дугаар сард эхлэх гэж байна.*

“Эрүүл мэндийн нээлттэй өдөр” сар бүрийн хоёр дахь 7 хоногийн Бямба гаригт орон даяар бүх хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нээлттэй байж тусламж үйлчилгээ үзүүлэх аяныг зохион байгуулж байна. Аяны гол зорилго нь оюутан, эмзэг бүлгийнхэн болон тодорхой оршин суух хаяггүй иргэдэд тусламж үйлчилгээг хүргэх юм. Эхний аяны хүрээнд 5600 иргэд хамрагдсан байна.

Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангах, чирэгдэлгүй үйлчилгээг дэмжих зорилгоор “Шуурхай үйлчилгээ - сэтгэл ханамж” нэг сарын аян явагдаж иргэд чирэгдэлгүйгээр яаралтай тусламж үйлчилгээ харьяалал харгалзахгүй авч байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ил тод болгох, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор харьяа эмнэлгүүдэд санал, хүсэлтийн хайрцгийг ажиллуулах, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн томилон ажиллуулах, 328111 дугаарын нээлттэй утсаар Эрүүл мэндийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авч байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтны ёс зүйг дээшлүүлэх зорилгоор НҮБ-ын дэмжлэгтэйгээр “Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглалын ёс зүй ба шударга ёсыг бэхжүүлэх” төслийг нэг жилийн хугацаатай хэрэгжүүлж эхэллээ.

Тусгай зөвшөөрлийн сунгалтын асуудлыг хөнгөвчилж мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулдаг байсныг зогсоолоо. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгаж байгууллага аж ахуйн нэгжийг чирэгдүүлдэг байсныг болиулж хуульд заасны дагуу 3 жилээс дээш хугацаагаар олгодог боллоо.

ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний стратегийг шинэчлэн боловсруулж байна. ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх хяналт шинжилгээний нэгдсэн тогтолцоог улсын хэмжээнд бий болгох асуудлыг зохион байгуулж байна.

- ✓ *Глобаль сан, олон нийтийн радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх, сэргийлэх талаар сурталчилгааг богино хугацаанд эрчимтэй хийсний үр дүнд ХДХВ/ДОХ/БЗДХ-ын шинжилгээнд хамрагсдын тоо 2,5-3 дахин өсөж өдөрт 650-800 болсон байна.*
- ✓ *Монгол Улсын Засгийн газарт Глобаль сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд тэмбүү өвчнийг илрүүлэх 70000, ХДХВ/ДОХ-ын 17000 хүний оношлуурыг нийлүүлж оношлогоо явуулах өргөн боломжийг бий болгосон бөгөөд Глобаль сангаас ХДХВ/ДОХ/БЗДХ-ын талаар авах арга хэмжээнд 4 сая ам.долларын тусламж үзүүлэх гэрээнд гарын үсэг зурсан.*

Халдварт Өвчин Судлалын Үндэсний төвд олон эмэнд дасалтай сүрьеэг оношлох, эмчлэх нөхцлийг бүрдүүлсэн 30 ортой тасгийг нээхэд бэлэн болоод байна.

ИКО менежмент компанитай “Залуус ДОХ-ын эсрэг хамтдаа” алхалтыг “Өнөөдөр шинжилгээ өгөөд маргааш итгэлтэй хариуцлагатай амьдарцгаая” уриан дор зохион байгуулсанд 400 гаруй хүн оролцсон.

ЭМЯ, НҮБ-ын Хүн амын Сан хамтран хэрэгжүүлж байгаа “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” хөтөлбөрийн шугамаар захиалан авсан НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний 215.0 сая төгрөгийн үнэ бүхий 20 гаруй нэрийн эм тариаг хот, хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагад хуваарилан үнэ төлбөргүйгээр олгосон.

Баянхонгор аймгийн Жаргалант, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Говь-Алтай аймгийн Бигэр суманд Сум дундын эмнэлэг байгууллаа.

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 02 тоот тушаалаар Сувилахуйн удирдлагын тогтолцоо, Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад “Сувилгааны алба байгуулах” тухай асуудлуудыг нэгдсэн журамд оруулан батлуулан гаргалаа.

“Сувилахуйн боловсролыг боловсронгуй болгох нь”, “Сувилахуйн удирдлага, манлайлал” сургалтыг хот хөдөөгийн 400 сувиллагчтайгаар зохион байгуулж, ОУСН-ийн “Өөрчлөлтийн үеийн манлайлал”- олон улсын хэмжээний сургалт төгсөгчдийн тайлан сургалтыг тус тус зохион байгууллаа.

Эрүүл мэндийн удирдах ажилтны “Байгууллагын хөгжлийг дэмжье” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгууллаа.

- ✓ *Уг зөвлөгөөнд Монгол Улсын эрүүл мэндийн салбарын 110 удирдах ажилтан оролцож эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад тулгарч буй асуудлууд болон Эрүүл мэндийн хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу гарах “Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах” зөвшөөрөл олгох, “Дадлагажигч эмч ажиллуулах” журмуудын төслийг боловсруулан хэлэлцүүлж, санал дүгнэлт гаргалаа.*

- ✓ *Зөвлөгөөнөөс “Байгууллагын хөгжлийг дэмжье” сэдэвт уриалга гаргаж, уг уриалгыг хэрэгжүүлэхээр харьяа байгууллагуудад хүргүүлэв.*

“Тамхигүй орчинд амьдарцгаая” сэдэвт шоуг 4000 гаруй залуучуудыг оролцуулан зохион байгуулав. Нийслэлийн 6 дүүргийн ЗДТГ-тай хамтран “Тамхигүй - эрүүл орчин” сэдэвт сургалтыг 200-аад баар рестораны эзэд менежерүүдийг оролцуулан зохион байгууллаа.

Иод дутлын эмгэгтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд “ИДЭТ хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилт” сэдэвт үндэсний бага хурлыг ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулав.

ХДХВ/ДОХ/БЗДХ-ын урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, халамжийн хүртээмжийг сайжруулах асуудлаар үндэсний зөвлөлдөх уулзалтыг НҮБ-ын салбар байгууллагууд, Герман-Монголын Засгийн газрын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, дотоодын төрийн болон төрийн бус 30 гаруй байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулсан бөгөөд үндэсний зөвлөлдөх уулзалтын талаар бүсийн зөвлөлдөх уулзалтанд танилцуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт

“Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж УИХ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороогоор хэлэлцүүлээ.

- ✓ *Энэхүү нэмэлт өөрчлөлтийн агуулга нь, боловсролын удирдлагын хариуцлагын болон ёс зүй, багш, суралцагчийн харилцааны хэм хэмжээг боловсронгуй болгох, багшийн нийгмийн баталгааг сайжруулах, боловсролын сургалтын байгууллагыг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэж байна.*

“Боловсролын мастер төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан хандивлагчид, олон улсын байгууллагын төлөөлөгчдөд танилцуулах, уулзалтыг зохион байгуулж мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай санхүүжилтийн талаар урьдчилан тохиролцож, хандивлагч байгууллагуудаар баталгаажуулах алхам хийсэн нь чухал ач холбогдолтой боллоо.

- ✓ *Энэ нь мастер төлөвлөгөөг олон улсын байгууллагуудын зүгээс хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаагийн илрэл бөгөөд Мастер төлөвлөгөөг батлан хэрэгжүүлснээр боловсролын талаар хэрэгжүүлэх тогтвортой бодлого, үйл ажиллагааны баримт бичигтэй болохоос гадна боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж, хандивлагчдын үйл ажиллагааны шинэ тогтолцоог буй болгож байгаа юм.*

ЕБС-ийн 1, 2 дугаар ангийн сурагчдад хичээлийн завсарлагаанаар өдрийн цайгаар үйлчлэх асуудлыг боловсруулж, хөрөнгийн тооцоог гарган 2007 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 4.8 тэрбум төгрөгийг тусгалаа.

- ✓ *“Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бага насны хүүхдийн сурах идэвхийг дээшлүүлж, бага боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэхэд болон тэдний эрүүл мэндийг хамгаалах, өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх, эх орны хүнсний үйлдвэрлэгчдийг дэмжих, шинээр ажлын байр бий болгох зэрэг олон талын үр дүнд хүрнэ.*

Ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлсэн, боловсролын шинэ стандартыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг шинэчлэх ажлыг эхлүүлж өнгөрсөн онд 17, энэ онд 30 нэрийн сурах бичгийг шинээр хэвлэснээр сурах бичгийн шинэчлэлийн 50 хувийг хэрэгжүүлэх бөгөөд сурах бичгийг хувилбартай, сонголттой болгосноор он удаан жил гар дамжин хэрэглэгдэж сургалт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй болсон сурах бичиг хэрэглэдэг тогтолцоог халж, сурах бичгийн зохиолын болон хэвлэлийн чанар, өнгө үзэмжийг сайжруулсан гэж үзэж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 11 жилийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийн төслийг хэлэлцэх үндэсний хэмжээний хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.

- ✓ *Эдгээр хэлэлцүүлэгт БСШУЯ-ны мэргэжилтэн, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд, их, дээд сургууль, туршилт хийсэн ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, эрдэмтэн багш нар оролцож хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг тусган 11 жилийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг 5 дугаар сард батлуулахаар бэлтгэж байна.*

ADRA олон улсын байгуулагаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол” төслийн шугамаар харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар сургууль, орон нутгийн боловсролын байгууллагуудад аудио студи, дохионы толь бичиг, кирилл фондоор бичигдсэн бичвэрийг яриа болгох программ, дижитал сургалтын хэрэгслийг хүлээлгэн өгч, дохионы хэлний анхны сурах бичгийг гаргасан нь сургалтын орчныг бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо ихээхэн олширсон өнөөгийн нөхцөлд иргэд сургууль, мэргэжлээ сонгох боломжийг өргөтгөх, шалгуулагч, элсэгчдэд учирч буй дарамтыг арилгах зорилгоор их, дээд сургууль, коллежид оюутан элсүүлэх журмыг шинэчилэн хуучин “конкурс”-ын журмыг халж “Ерөнхий шалгалт-ыг авах боллоо.

- ✓ *Ерөнхий шалгалтыг нэг удаа, улсын хэмжээнд 2006 оны 5 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд авахаар шийдвэрлэлээ.*
- ✓ *Элсэлтийн шалгалтад 38.7 мянган хүн орохоор бүртгүүлээд байна.*
- ✓ *Дархан-Уул аймагт туршилтын шалгалтыг зохион байгуулах дүнгээс үзэхэд, шинэ журмаар шалгалтыг зохион байгуулах бүрэн боломжтой нь харагдлаа. Уг шалгалтын дүнд дүгнэлт хийж, анхаарах асуудлыг тодруулан, цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.*

Монгол Улс, Австри Улсын хооронд боловсролын баримт бичиг харилцан хүлээн зөвшөөрөх тухай гэрээнд Австри улсад хоёр орны боловсролын сайд гарын үсэг зурлаа.

- ✓ *Үүний үр дүнд хоёр улсын боловсролын баримт бичиг харилцан хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй Европын орнууд эл асуудалд нааштай хандах боломжийг өргөжүүлж бүрэн дунд боловсрол эзэмшсэн манай иргэд Австрийн их, дээд сургуульд шууд элсэн суралцах мөн боловсролын гэрчилгээ, мэргэжлийн дипломоор тус улсад ажиллах эрх зүйн үндэс бүрдлээ.*

Өндөр хөгжилтэй орны дээд боловсролын сургалтын байгууллагыг Монгол Улсад байгуулах, иргэдэд чанартай боловсрол эзэмшүүлэх зорилгоор Харт Фордын их сургуулийн салбарыг байгуулаад байна. Энэ нь өндөр хөгжилтэй орны их сургуулиудын эзэмшүүлж буй боловсролыг эх орондоо, хямд зардлаар эзэмших боломжийг бүрдүүлэх эхний алхам боллоо.

Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2006-2007 оны хичээлийн жилд Япон, ОХУ, БНХАУ, Польш, Унгар, Турк, Укриан, Казахстан улсын их, дээд сургуульд оюутан, магистрант, докторант, мэргэжил дээшлүүлэгч нарыг суралцуулах сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж 496 залуучууд суралцах эрхээ аваад байна.

Төрийн өмчийн 49, төрийн бус өмчийн 165 дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн эзэмшилт, олгосон гэрчилгээ, түүнийг сунгасан байдал, мөн хүчингүй болгосон тухай мэдээллийг багтаасан нэгдсэн лавлагааг бий болгосны гадна сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл, хяналтын үзүүлэлтийг хэрхэн ханган биелүүлж байгаа байдлаар нь зохих түвшинд, дундаж түвшинд, дунджаас доогуур гэсэн 3 түвшинд ангилсан судалгаа гаргаад байна. Ингэснээр ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг олон байгууллагад чанарын зэрэглэл тогтоож, тэдгээрийн тухай мэдээллээр олон нийтийг хангадаг боллоо.

Сүүлийн нэг жилд МСҮТ-д суралцагчдын тоо 1.2 мянгаар өссөн бөгөөд энэ чиглэлээр суралцагчдын тоо нэмэгдэж буйтай холбогдуулан мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд зориулж нэг тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж хичээл, дадлагын болон дотуур байрны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүллээ.

Оюутны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрх ашгийг хамгаалах, шийдвэр гаргахад тэдний саналыг тусгах, оролцоог хангах талаар ахиц дэвшил гарч байна.

Оюутны гудамж, талбайг тохижуулах, сургуулийн газрыг баталгаажуулах, оюутны хотхоны газар олгох, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, унааны хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээг Нийслэлийн Засаг даргатай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний сацуу их, дээд сургуулийн оюутны бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, уг арга хэмжээнд нийт 23 сургуулийн оюутны 2000 гаруй бүтээл тавигдлаа. Эл үзэсгэлэн нь тэдний оюуны чадавхи, бүтээлч сэтгэлгээний чадавхыг харуулсан ажил боллоо.

Одоогийн байдлаар улсын төсвийн санхүүжилтээр мөн Дорнод аймагт 640 хүүхдийн, Дорноговьд 920 хүүхдийн шинэ сургуулиудыг, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дорнод аймагт 250 суудал бүхий сургууль, цэцэрлэгийн барилгын цогцолбор, “ЖАЙКА” олон улсын байгууллагын санхүүжилтээр нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт тус бүр 640, Чингэлтэй, Хан-уул дүүрэгт тус бүр 720 хүүхдийн сургуулийн өргөтгөлийг ашиглалтанд оруулснаар нийт 4538 суудал шинээр буй болгож, ээлжийг багасган, хүүхдийн сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүллээ.

Аймаг, нийслэлд 7.0 сая төгрөгийн компьютер, хөгжим, принтер олгож, АНУ-ын “Охана сан”-аас ирүүлсэн англи хэлний 500 ширхэг электрон сурах бичиг, DVD-ийг нийслэл, орон нутгийн ЕБС-дад хүргүүллээ.

Өнгөрсөн онд ерөнхий боловсролын нэг сургуульд 7 компьютер ногдож байсан бол одоо 9 компьютер ногдох болж бодитой ахиц гарлаа.

“Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж Засгийн газарт өргөн барив.

- ✓ *Хуулийн нэмэлт өөрчлөлт нь дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн болон соёлын өвийг хамгаалахад зориулж төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, соёлын ажилтны ёс зүйн хэм хэмжээг зохицуулах, соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг зах зээлийн харилцаанд нийцүүлэхэд чиглэж байна.*

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд Австри улсад “Чингис хаан ба түүний өв залгамжлагчид” үзэсгэлэн, Монгол Улсын соёлын өдрүүдийг зохион байгууллаа.

800 морин хуурч, 800 уртын дуучдыг бэлтгэх ажлыг улс даяар зохион байгуулж, эл бүтээлд оролцох хуурчид, дуучдын нэрсийг гарган тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Ховд аймагт Алтайн туульс, хөөмийн баяр, Баян-өлгий аймагт Казах ардын урлагийн баяр, Увс аймагт Бий, биелгээчдийн өдөрлөг-наадмыг амжилттай зохион байгууллаа. Энд 5 улс, 6 аймаг, 51 сум, 800 гаруй авъяастан, уран бүтээлчид түүний дотор 130 гаруй хөөмийч, 30 шахам туульч, 200 гаруй бийч оролцсон соёлын томоохон чуулгауулзалт боллоо.

Сүүлийн жилүүдэд орхигдож бүдгэрсэн утга зохиолын шүүмжийг сэргээж хөгжүүлэх зорилгоор утга зохиолын шүүмжийн улсын уралдааныг зохион байгуулж шилдэг 5 бүтээлийг сонгон шалгаруулав.

“Цахим номын сан” төслийн эхний үе шатыг амжилттай хэрэгжүүлж дуусгав. Энэ ажлын хүрээнд 15 боть зохиол, хүүхдийн 40 гаруй номыг тоон системд оруулсны зэрэгцээ 3000 ширхэг CD бэлтгэж уншигч, хэрэглэгчдийн хүртээл болгосон нь интерентэд холбогдоогүй номын сан, сургуулиуд цахим номын санг CD хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүллээ.

ЮНЕСКО-той “Номын сангууд мэдээллийн цэлгэр хаалга” төслийг хамтран хэрэгжүүлж, үндэсний цөөнх болох казах, цаатан, буриад угсаатны амьдардаг аймгийн сумдын номын санд 30.000 ам.долларын ном, хэвлэл хандивлах арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнтэй боллоо.

Засгийн газрын 2006 оны 70 дугаар тогтоолоор Булган аймгийн Дашинчилэн сумын Хар бухын балгас, Цогт тайжийн Цагаан байшингийн хамгаалалтын бүсийг тогтоож баталсан нь түүх, соёлын үнэт өвийг хамгаалж бэхжүүлэх ач холбогдолтой болов.

Хүүхэд залуучуудад үндэсний түүх соёлоо мэддэг, түүгээрээ бахархаж, хайрлан хамгаалдаг үзлийг төлөвшүүлэх, музейг сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болгож үйл ажиллагааг нь өргөтгөх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад улсын музейнүүдийг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулж 4000 мянга гаруй хүүхдүүдэд үйлчлээд байна.

БНАСАУ-д жил бүр зохиогддог “Хаврын баяр” олон улсын наадамд Дуурь, бүжгийн эрдмийн театр, Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулга, Улсын цирк, Төв аймгийн хөгжимт

драмын театр, Хэнтий аймгийн “Хан Хэнтий” чуулга, Завхан аймгийн ХДТ, Үндэсний дуу, бүжгийн “Түмэн эх” чуулга, Сарны чуулга, чөлөөт уран бүтээлчид оролцсон 36 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцлоо. Уг наадамд 35 оны 800 гаруй төлөөлөгчид оролцсоноос манай уран бүтээлчид 4 төрөлд 11 алт, мөнгөн цом хүртсэн нь уран бүтээлчдийн чадвар, бүтээлийн чанар ахиж байгааг харуулж байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарт 2006-2008 онд Оросын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны сан, ӨМӨЗО-ы Шинжлэх ухаан, техникийн танхимтай тус тус хамтран хэрэгжүүлэх 21 төслийг шаардагдах зардлын хамт батлан хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн хүрээнд түүх соёлын судалгааны ажлуудаас гадна “Цаг уурын өөрчлөлт Монгол Улсын эко эдийн засгийн тогтолцоонд нөлөөлж байгаа нь”, “Чихрийн манжин тариалах эрдэм шинжилгээ, туршилт судалгааны төсөл”, “Увс аймгийн Бөхмөрөн суманд барих нүүрсний хийгээр ажиллах цахилгаан станцын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах” зэрэг эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хэд хэдэн төсөлт ажлууд хийгдэнэ.

Залуу эрдэмтдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 айлын орон сууц барих ажлыг эхлүүлэх боллоо.

Гурав. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжирч байна. Эдийн засаг, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, төсвийн орлогын баазыг сайжруулах, төсвийн зарлагын үр ашгийг дээшлүүлэх, улсын санхүүгийн нөөцийг арвижуулах, үндэсний үйлдвэрлэлийг мөнгө, татварын бодлогоор дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангахад түлхүү анхаарч ажиллаж байна. Эдийн засгийн бодит өсөлт 2005 онд 6.2 хувьтай гарч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 740 ам.долларт хүрлээ. Энэ байдалд дэлхийн зах зээл дээр зэс, алтны үнэ өндөр, цаг агаарын харьцангуй тааламжтай байсан явдал бараа, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтэд эерэг нөлөөлж, эдийн засгийн өсөлтөд ихээхэн дэмжлэг үзүүллээ. Хөрөнгө оруулалтын хууль эрхзүйн таатай орчныг зохих ёсоор бүрдүүлснээр уул уурхайн салбарын гадаад хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг урьдын адил дэмжсэнээр эдийн засагт хувийн хэвшил давамгайлах байдал улам нэмэгдэж байна.


Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2006 оны үндсэн чиглэлийн арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байна. Үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах ажлын хүрээнд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга, хэлбэрийг баяжуулж, хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлогын гол зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дунд хугацаагаар буюу 3 жилээр тодорхойлон томъёолж, түүнийг хэрэгжүүлэх явдал хойшлуулшгүй зорилт болсон юм. Энэ байдалд дүгнэлт хийж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг шинэ аргазүйгээр боловсруулж УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт, улсын төсөв болон авто замын сангийн хөрөнгөөр 2006 онд баригдах зам, гүүрийн барилга байгууламжийн жагсаалтыг тус тус батлав.

- ✓ **Жагсаалтаар 6,098.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 220 орчим нэгж (объект)-ийн их засварын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэв.**

Монгол Улсын 2006 оны эхний улирлын төсвийн орлогын төлөвлөгөөг 12.2 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62.3 тэрбум төгрөгөөр буюу 40 хувиар илүү байна.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, /эхний улирлын байдлаар/



Засгийн газар нийгмийн нэн тулгамдсан багц асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс Монгол Улсын төсвийн тодотголыг анх удаа оны эхний хагас жилд багтаан батлуулж байна. Улсын 2006 оны төсвийн тодотголоор 2006 оны төсвийн орлого **1037.2** тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас **186.0** тэрбум төгрөгөөр, 2006 оны төсвийн зарлага **1,123.1** тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас **188.1** тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдэж байна. Улсын төсвийн тодотголоор 2006 оны хөрөнгө оруулалтын хэмжээ **137.5** тэрбум төгрөгт хүрч батлагдсанаас 44.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, өнгөрсөн оныхоос 2 дахин өсч байна. Төсвийн тодотголоор Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой 7.2 тэрбум төгрөгийн, гадаад орнуудтай байгуулсан эрчим хүч, авто замын салбарын гэрээ, хэлэлцээрээр Засгийн газрын хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулахад 12.2 тэрбум төгрөгийн, түүнчлэн хөдөөгийн малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангахад 9.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгасан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

- Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийг Засгийн газрын тогтоолоор батлуулж, гэрээ байгуулах эрх олгохын өмнө 1.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй ажил, 200.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй зөвлөх үйлчилгээ болон 800.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй бараа, бусад үйлчилгээ худалдан авах ажиллагаанд Сангийн яамаар урьдчилан хянуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэр гаргаж байх журам тогтоосон.
- Цахим сүлжээнд тендерийн зар, үр дүнг зарлан мэдээлэх тухай журмын дагуу одоогоор шалгаруулалтын урилга зарлан мэдээлэх зөвшөөрөл 12, гэрээ байгуулах зөвшөөрөл 11 (нийт 23 зөвшөөрөл) олгогдсон байна.

Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Япон, ХБНГУ, Швейцарь, Испани, Бельги, Итали зэрэг хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагатай зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх чиглэлээр идэвхтэй хамтарч ажилласны дүнд хөнгөлөлттэй зээлийн 48.9 сая ам.долларын 4 гэрээ, техникийн буцалтгүй тусламжийн 23.1 сая ам.долларын 11 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх (нийтдээ 72.0 сая ам.долларын) гэрээ, хэлэлцээр байгууллаа.

БНХАУ-ын Засгийн газартай 300 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулахаар болж, эх үүсвэрийн 240 сая нь орон сууцны нөхцөл сайжруулах, зам барих зэрэг бүтээн байгуулалтад, 60 сая нь Засгийн газар мэдэж зарцуулахаар болж байна.

Дэлхийн банктай хамтран Монгол Улсын Засгийн газар-гадаад түншүүдийн хамтарсан техникийн уулзалтыг амжилттай зохион байгууллаа.

- Уулзалтаар гадаадын зээл, тусламжийн харилцан уялдаа, тэдгээрийн үр дүнг тодорхойлоход чиглэсэн удирдлагыг сайжруулах, өрийн удирдлага, хувийн хэвшлийн хөгжил, боловсролын салбарын асуудлаар ярилцав.
- Энэхүү уулзалт нь Монгол Улсад хөгжлийн хамтын ажиллагааны шинэ чиг хандлагыг нэвтрүүлэх, улмаар гадаадын зээл, тусламжийн бодлогыг

үндэсний хөгжлийн стратеги, улсын төсөв болон хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулах анхны чухал алхам боллоо.

- Засгийн газар гадаад түншүүдтэйгээ хамтарч гадаадын зээл, тусламжийн шинэ арга хэрэгслийг тохиролцсон төдийгүй техникийн уулзалтыг зургаан сар тутам зохион байгуулж байх эхлэлийг тавьсан явдал ололт хийгдлээ.
- Энэхүү шинэ арга хэрэгсэл нь монголын эдийн засгийн бодит хөгжлийг дэмжсэн, үр дүнд суурилсан, аливаа давхардлыг арилгасан, эргэж тайлагнадаг, ил тод байх зарчимд тулгуурлахад оршиж байна.

Засгийн газрын 23 төрлийн тусгай сангуудыг байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх болон захиран зарцуулах зэрэг харилцааг зохицуулсан эрхзүйн нэгдсэн зохицуулалт одоо хэр байхгүй явж ирснээс сангуудын үйл ажиллагаа Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөх явдал цөөнгүй гарч байна. Тусгай сангуудад төвлөрүүлдэг гадаад, дотоодын хандивын хөрөнгө хэдийгээр тусгай зориулалтаар олгогдож байгаа ч гэсэн Засгийн газарт олгосон хөрөнгө учраас түүний бүртгэл, тооцоо, зарцуулалтад хяналт тавих тогтолцоог зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай болсон юм. Түүнчлэн тусгай сангуудын дансыг цэгцлэх, хөрөнгө зарцуулах эрхийг журамлах, орлого, зарлагыг батлах, бүртгэх, гүйцэтгэлийг тооцох нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зэрэг эрхзүйн зохицуулалт хэрэгтэй байна. Засгийн газрын тусгай сангийн тухай болон түүнтэй холбогдуулан зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн бариад байна. Өнөөдөр алт, зэсийн үнийн өсөлтөөс хуримтлагдсан нэмэгдэл орлогыг тусгай санд төвлөрүүлж алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ буурсан тохиолдолд түүнийг төсвийн орлогын бууралтыг нөхөхөд ашиглахаар төлөвлөж байна.

Монгол Улсын татварын бодлогын шинэчлэлийн хүрээнд Татварын багц хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

- Татварын багц хуулиудын агуулга 1/ татварын зөв тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх; 2/ бизнес эрхлэгчдэд ногдох татварын ачааллыг бууруулах замаар тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; 3/ татварын дарамтыг багасгаж, далд эдийн засгийг хязгаарлаж, татвар төлөгчдийн эгнээг өргөтгөх; 4/ гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж ирсэн татварын давуу байдлыг арилгаж, дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч нарт нэг адил нөхцөл олгоход бүхэлдээ чиглэгдэж байгаа юм.

Үйлдвэр, худалдааны салбарт

Үйлдвэр, худалдааны яамнаас олгож буй зөвшөөрөл, лицензийн талаар бизнес эрхлэгчид, иргэд, аж ахуйн нэгж байгуулагуудад зориулсан мэдээллийн самбар гарган тогтмол ажиллуулж байна.

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлд хууль, эрх зүйн хүрээнд дараах хуулийн төсөл, бодлогын баримт бичгийг боловсруулаад байна.

- “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийн төсөл
- “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл
- Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- Ноолуур, тэмээний ноос, хонины нарийн ноос боловсруулах цогцолбор, арьс ширний үйлдвэрлэлийн цогцолбор барих төслийн баримт бичиг

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санхүүгийн зөв оновчтой механизм тогтоох үүднээс “Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт, хөгжлийн сан”-г Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Улаанбаатар банктай хамтран туршилтын журмаар байгуулав. Уг сангаас одоогийн байдлаар 30 гаруй сая төгрөгийн зээлийг жилийн 16-18 хувьтай олгоод байна.

Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний салбарын үндсэн, туслах материал, сэлбэг хэрэгсэл, түүхий эдийг импортын болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарын ажил олгогчдоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийг 50 хувь хөнгөллөө.

“Модон түүхий эд материалыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”-ийг батлуулав. Модон бүтээгдэхүүнийг гүнзгий боловсруулж, экспортлох чиглэлээр “Зарим бараанд ногдох экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг УИХ-д өргөн бариад байна.

Малын гаралтай түүхий эд, ялангуяа ямааны ноолуурыг дотооддоо иж бүрэн боловсруулах хүчин чадлыг бий болгох зорилгоор цогцолбор төсөл боловсруулах, уг төслийг хэрэгжүүлэх зээл, тусламжийг гадаад орон, олон улсын байгууллагаас авах, энэ чиглэлд хамтран ажиллахаар яриа, хэлэлцээ хийж байна.

ЖДҮ-ийг дэмжих үндэсний хэлэлцүүлгийг хот, хөдөөд зохион байгуулж 2010 он хүртэл хэрэгжүүлэх “ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг батлууллаа. Үүний үндсэн дээр Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

2006 оны хувьд Баян-Өлгий, Өвөрхангай аймагт бөөний худалдааны сүлжээг байгуулах ажлыг эхлүүлнэ.

Хивс, нэхий эдлэл, шеврет, шевро, боловсруулсан үхрийн шир, сүлжмэл эдлэл болон зарим хүнсний бүтээгдэхүүн зэрэг дотоодод үйлдвэрлэдэг 6 бүлгийн 13 зүйлийн бараанд импортын татварыг ялгавартай тогтоох асуудлаар УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн бариад байна.

ЖДҮ-ийг дэмжих зорилгоор техник, технологи, машин тоног төхөөрөмжийг лизингээр олгох эрх зүй, татварын таатай орчин бүрдүүлэх “Лизингийн тухай хууль”-ийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Санхүүгийн бодлогоор жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих үүднээс Японы Засгийн газраас энэ оны 2 дугаар сард 2 үе шаттай зээл авах асуудлыг Засгийн газар шийдэж байна. Төслийн шугамаар 20 гаруй сая ам долларын хөнгөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгоно. Үүнд ялангуяа хөдөө аж ахуйн салбар дахь аж ахуйн нэгжүүдийг дэмжих юм.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих технологи хөгжлийн сангийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх сангийн схем, ажил үүргийн бүдүүвчийг боловсруулж Үйлдвэр, худалдааны сайд Бүсийн зөвлөлийн дарга нартай Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих технологи хөгжлийн санг орон нутагт хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг 2006 оны 1 дүгээр сард байгуулав.

Пиво, ундааны лаазыг татваргүйгээр экспортлох асуудлыг шийдвэрлүүлэв.

Арьс ширний үйлдвэрүүдийн аттестатчиллыг хийж, Арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Хэвлэлийн үйлдвэрлэлийн холбоо, Ойчдын Нэгдсэн Холбоо, Мах үйлдвэрлэгчдийн холбоодын удирдлагуудтай уулзалтыг зохион байгуулав.

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт:

Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлд хууль, эрх зүйн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн бариад байна.

- *Хуулийн төслийг боловсруулахдаа ашигт малтмалын асуудлаар нийгэмд үүсэн бий болоод байгаа уур амьсгал, иргэний хөдөлгөөнүүдээс дэвшүүлж буй санал, шаардлага, хөрөнгө оруулагчдын санал, гадаад улсын туршлага, олон улсын байгууллагуудын гаргасан зөвлөмж зэргийг нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийж, иргэний хөдөлгөөн, хөрөнгө оруулагчид, тус салбарын эрдэмтэд, судлаачдыг оролцуулсан хэд хэдэн уулзалт ярилцлага зохион байгуулж, тэдний саналыг харгалзан салбарын хөгжлийн эрх ашиг, тус салбараас улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь оролцоог нэмэгдүүлэх асуудлын тэнцвэрийг хангахад анхаарсан болно.*

Ашигт малтмалыг хууль бусаар олборлох ажиллагааг зохицуулах тийм хөдөлмөр эрхэлж хүмүүсийг зохион байгуулалтад оруулах зорилгоор Ашигт малтмалыг гар үйлдвэрлэлийн аргаар олборлох тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хууль батлагдсан, одоо хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

- Энэ хүрээнд газрын тосны бүтээгдэхүүнийг бөөнөөр импортлох, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох журам боловсруулж, батлаад байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын томоохон ордуудыг эзэмшихэд төрийн зүгээс хэрхэн оролцох, хувь эзэмших асуудлыг хариуцан гүйцэтгэх чиг үүрэг бүхий Төрийн өмчийн үйлдвэрийн газар байгуулах тухай танилцуулга, Засгийн газрын тогтоолын төсөл, уг байгууллагын дүрмийн төслийг боловсруулж ажлын хүрээнд томоохон орд газруудын жагсаалт гаргаж, томоохон ордуудыг түшиглэн байгуулагдах уулын үйлдвэрүүдэд Монголын төрийн оролцоог бий болгох асуудлаар ашигт малтмалын лиценз эзэмшигч нартай хэлцэл хийх удирдамжийн төслийг бэлтгэв.

Ашигт малтмалын лиценз шинээр олгох, улсын төсвийн хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон, цаашид төрийн өмчийн оролцоотойгоор ашиглах ордуудыг тогтоож, эдгээр ордуудын лицензийг шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай УИХ-ын тогтоолын төслийг үзэл баримтлалын хамт боловсруулав.

2006 оны эхний улирлын байдлаар 129.5 мянган тонн зэсийн баяжмал, 644.0 тонн молибдений баямал, 2.8 тн алт, 24.0 мянган тонн хайлуур жоншны баяжмал, 24.6 мянган тонн цайрын баяжмал, 3.5 мянган тонн төмрийн хүдэр олборлосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийт дүнгээрээ 1.2 хувиар өссөн нь 2006 оны эцэст уул уурхайн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оныхоос нэмэгдэхээр байна. Цавын уулын үйлдвэр энэ оны эхний хагаст ашиглалтанд оруулах ажлыг зохион байгуулна. Мөн онд 1.8 сая тонн нүүрс, 55.7 мянган баррель газрын тос олборложээ.

Энэ хугацаанд боловсроогүй буюу хагас боловсруулсан алт 2.3 тн, зэсийн баяжмал 140.7 мянган тонн, молибдений хүдэр, баяжмал 0.9 мянган тонн, жоншны баяжмал 37.6 мянган тонн, нүүрс 295.3 мянган тонн боловсруулаагүй нефть 15.1 мянган баррелийг тус тус экспортлосон байна.

Төмөртийн Овооны уулын баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтанд улсын комиссын хүлээн авав.

Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрэл болон 1:200000-ны масштабын хүндийн хүчний ажлуудын төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий 8 шинээр 8 төслийг 10100 км² талбайд эхлүүлж, өмнөх онуудаас үргэлжилж байгаа 10 төслийн 14609.47 км² талбайд үргэлжлүүлж 7 төслийн үр дүнгийн тайлан хүлээж авна

“Монгол Улсад өнгөт металл болон хар төмөрлөгийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бололцоо”-ны талаар стратеги төлөвлөгөө боловсруулж байна. “Монгол Улсын металлургийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г үндэслэн “Уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын холбогдох асуудлын хүрээнд эрдэс баялгийн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж зохицуулалтын асуудал” судалгааг хийж байна.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны салбарт:

ОХУ-тай Шинэ зах зээлийн бодлогын хүрээнд юуны өмнө ОХУ ДХБ-д элсэхтэй холбогдуулан яриа хэлэлцээг эцэслэж, дундаж тарифын хэмжээг 11-12 хувь хүртэл бууруулав.

- ✓ ОХУ-ыг ДХБ-д элсмэгц тус улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллахаар ОХУ-ын Эдийн засгийн хөгжил, худалдааны яамтай тохиролцсон нь манай хойд хөршийн зах зээлд татваргүй нэвтрэх эхлэлийг тавьсан ач холбогдолтой алхам боллоо.
- ✓ Хоёр орны хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар илүү баяжуулах үүднээс “Монгол Улс, ОХУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр яриа, хэлэлцээ хийж байна.

Европын Холбооны 25 оронд 7200 нэр төрлийг барааг татваргүй оруулах эрхийг Монгол Улс анх удаа авсан бөгөөд дэлхийн 10 орныг хамарсан Европын Холбооны тусгай хөнгөлөлтийн хөтөлбөр нь 2008, улмаар 2015 он хүртэл үргэлжилнэ.

Олон улсын худалдаа зах зээл судлалын төвийн үйл ажиллагааны хүрээнд “Монгол-АНУ-ын чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж” сэдэвт Үндэсний хэлэлцүүлгийг 2 дугаар сард зохион байгуулж “Монгол Улс-АНУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж, тулгамдсан асуудлууд” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Монгол Улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчдийн газруудын 2006 оны ажилд анхаарах асуудлаар ерөнхий чиглэл боловсруулж, Дипломат төлөөлөгчдийн газруудын худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан дипломат ажилтны зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шугамаар Худалдааны бодлого хэлэлцээнд дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлэхээр тохиролцож холбогдох баримт бичиг гарын үсэг зурав.

Монгол-АНУ-ын Худалдаа хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн II хуралдаанд оролцохтой холбогдсон бэлтгэл ажлыг хангаж хуралдаанд оролцож, АНУ-ын Төрийн департамент, Худалдааны яам, Худалдаа хөгжлийн агентлаг, Экспорт-импортын банк, Дэлхийн банк зэрэг байгууллагын удирдах албаны хүмүүстэй хоёр талын уулзалтууд хийж худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцов.

Монгол-Америкийн дугуй ширээний уулзалт 3 дугаар сарын 10-нд зохион байгуулж худалдаа, хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар харилцан мэдээлэл хийж ярилцлага явуулав.

Торонто хотноо зохиогдсон уул уурхайн салбарын олон улсын 74 дэх чуулга уулзалт, үзэсгэлэнд үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан тэргүүтэй монголын төлөөлөгчид оролцов. Тэрээр энэ салбарын гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хууль эрх зүйн ижил тэгш нөхцөл бүрдүүлэх, харилцан ашигтай үйл ажиллагаа явуулахын чухлыг онцлов. Мөн Канадын Байгалийн нөөцийн яамны болон зарим компанийн удирдлагуудтай уулзаж санал солилцож хэлэлцээ хийв.

Дөрөв. ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГЫН ТАЛААР

Барилга, хот байгуулалтын салбарт

Мянганы сорилын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр “Гэр хорооллыг хөгжүүлэх төсөл”-ийг боловсруулж хэрэгжүүлэх талаар АНУ-ын Мянганы Сорилын Корпорацийн холбогдох хүмүүстэй хамтран ажиллаж байна. Төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны меморандиумын төслийг боловсруулж, МСС-ын үндэсний зөвлөл, Мянганы сорилын корпорацид хүргүүлэв.

Гэр хорооллыг орон сууцны хороолол болгож өөрчлөх, дэд бүтцээр хангах концепцийг боловсруулж 950 сая төгрөгийн төслийг Улаанбаатар хотын гэр хороололд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах асуудлыг Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, Засгийн газрын 2006 оны 37 дугаар тогтоолоор орон сууцны бодлого болон “40000 орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Орон сууцны үндэсний төв”-ийг шинээр байгуулан ажиллуулж байна.

“40000 орон сууц” хөтөлбөрт оролцох хүсэлтэй байгууллага, аж ахуйн нэгж хөтөлбөрт хамрагдаж орон сууцтай болохыг хүссэн иргэдийн санал хүсэлтийг судлан үзэж, бүртгэл судалгаа хийн хөтөлбөрийн хүрээнд орон сууц барих газрын зөвшөөрөлтэй, хөрөнгийн эх үүсвэрээ шийдвэрлэсэн төсөл боловсруулан ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудад хөтөлбөрт оролцогчийн батламжийг олгож эхлээд байна.

Засгийн газрын 60.0 тэрбум төгрөгийн бонд гаргах асуудлыг УИХ-ын нэгдсэн чуулганд оруулахаар болоод байна.

- ✓ *Энэ ажил хийгдсэнээр Улаанбаатар хотод нийтийн зориулалттай орон сууц 1600, аймгийн төв тус бүрт 40, сумын төв тус бүрт 4 айлын нийт 3760 айлын сууц болон Улаанбаатар хотод 1000 оюутны дотуур байр барих, гэр хорооллын 2000 айлыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож орон сууцны хороолол болгон өөрчлөх, Аймгийн төв, суурин газрын цэвэр усны*

нэгдсэн шугам сүлжээнд холбогдсон нийтийн зориулалттай 4000 орон сууцыг хэрэглээний байнгын халуун устай болох нөхцөл бүрдэнэ.

“Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай” багц хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын хаврын чуулганы хуралдаанд оруулахаар ажиллаж байна.

“Зарим материал, тоног төхөөрөмж, машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай” хууль, “Зарим материал, машин механизм, тоног төхөөрөмж, бараа, ажил үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулиуд болон тэдгээрийн заалтын дагуу Засгийн газрын 2005 оны 193 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, барилгын салбарт шинэчлэл хийх зориулалттай импортоор оруулж ирсэн 1.0 сая ам. долларын өртөг бүхий машин механизм, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлснөөр нийт 200 орчим мянган ам.долларын хөнгөлөлт хийсэн байна.

Мөн хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд орон сууц барьсан 39 аж ахуйн нэгжийн орон сууцны борлуулалтад ногдох 3.6 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна.

Төвийн болон зүүн бүсийн 8 аймгийн нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хүрээнд орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах, гэр хорооллын 426 айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох, 2100 ширхэг агшин зуурын цахилгаан ус халаагуур суурилуулах зэрэг ажлуудыг хийхээр АХБ-тай харилцан тохиролцов.

Зам тээврийн салбарт

Монгол Улсын авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, “Мянганы зам” төсөл, Азийн авто замын сүлжээний замуудын чиглэлийг уялдуулах зорилгоор Монгол Улсын авто замын сүлжээг дунд хугацаанд буюу 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөөллийг боловсруулаад байна.

Улсын төсөв болон авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2006 онд хэрэгжүүлэх авто замын барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтад тодотгол хийх санал, 2007-2009 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийг боловсруулж холбогдох газруудад оруулснаар 2006 оны төсвийн тодотголд 8.0 орчим тэрбум төгрөгийг нэмэгдүүлэх асуудал УИХ-аар хэлэлцэгдэж шийдвэрлэгдэж байна.

Авто замын салбарт 2006-2008 онд хатуу хучилттай 1500 км зам барих, 1000 гаруй км хөрсөн замыг сайжруулах, 573.4 м төмөр бетон гүүрийг барьж ашиглалтад оруулахаас 2006 онд хатуу хучилттай 284 км замыг барьж ашиглалтад оруулах, 324 урт метр төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулах юм.

Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг болох “Мянганы зам”-ыг үргэлжлүүлэн барих ажлыг эрчимжүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр баригдах Улаанбаатар-Эрдэнэсант чиглэлийн 176 км хатуу хучилттай авто замын их засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийг боловсруулаад байгаа бөгөөд Хархорин-Цэцэрлэг, Өндөрхаан-Сүмбэр, Дашинчилэн-Цэцүүх-Тосонцэнгэл-Улиастай-Улаангом чиглэлийн замуудын хайгуул зураг төслийг боловсруулах техникийн даалгаврыг гаргаад байна. Эдгээр замуудын хайгуул, зураг төслийг хийхэд 1,4 тэрбум төгрөг шаардагдаж байгаа юм.

Авто замын сүлжээгээ өргөтгөн шинэ зам барихаас гадна барьчихсан зам, гүүрээ арчлан хамгаалж, үйлчилгээний түвшинг хангах ажилд бид анхаарлаа хандуулж байна. Авто зам, гүүрийн засварын ажилд 2006 онд 6.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж авто замын засвар, арчлалтын компаниудтай зам, гүүрийн байнгын засвар арчлалтын гэрээг байгуулаад байна.

Дээрх хөрөнгөөр улсын чанартай 11123 км авто зам, 8251 у/м гүүрийг орон нутгийн болон бүс нутаг хариуцсан засвар арчлалтын 14 компанитай гэрээ байгуулж байнгын болон урсгал засвар арчлалтыг хийж гүйцэтгэж байна.

Азийн авто замын сүлжээний чиглэлд “Баруун бүс-Алтайн зам”-ын техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаатайгаар гүйцэтгэхээр тохиролцоод байна.

✓ *Уг замын зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаар Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант чиглэлийн замын Азийн хөгжлийн банк болон олон улсын банк, санхүүгийн байгууллагын хөрөнгө оруулалтаар барих үндэс бүрдэх юм.*

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжих “Зүүн чиглэлийн гол авто зам барих” төслийн нээлтийн ёслолын ажиллагааг 4 дүгээр сарын 21-ний өдөр Багануур дүүрэгт зохион байгуулав.

✓ *Энэхүү төслөөр 2006-2008 онд Багануур Өндөрхааны чиглэлд 58.5 км зам барих бөгөөд төсөл хэрэгжиж дууссаны дараа уг зам барилгад ашигласан 71 машин механизм, тоног төхөөрөмжийг Монголын талд хүлээлгэн өгөх юм.*

Герман Улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл”-ийн дотоодын гүйцэтгэгчийг сонгох, Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 46 км зам барих төсөл”-д хяналт хийх зөвлөхийн техникийн санал, Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын “Эксим” банкны зээлээр хэрэгжих “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-ийн зөвлөхийн санхүүгийн саналыг тус тус үнэлж холбогдох банкуудад хүргүүлсний зэрэгцээ Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 247 км замын гүйцэтгэгчийг сонгох тендерийн үнэлгээг эхлэв.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Зүүн чиглэлийн гол авто зам барих төсөл”-ийн гүйцэтгэгч “Конейка” ХК болон “ИТОЧУ” компанийн нийлүүлэх тоног төхөөрөмжийг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг Сангийн яаманд, зам барилгын ажилд шаардлагатай орон нутгийн элс, хайрганы карьерыг ашигласны төлбөрийг орон нутгийн татвараас чөлөөлөх асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэв.

Япон Улсын Засгийн газрын тусламжаар баригдах Багануур-Өндөрхаан чиглэлийн 58 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ онд шинээр Завхан, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад Германы Сэргээн босголтын банкны зээлээр “Бүс нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх” төслийн хүрээнд баригдах 96 км хайрган хучилттай замын, Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Засгийн газрын зээлээр хэрэгжүүлэх Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 431.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлуудыг эхлүүлнэ.

Автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хууль бус тээвэрлэлтийг таслан зогсоох зорилгоор Өмнөговь аймгийн Нарийн сухайтын нүүрсний уурхайгаас Шивээ хүрэн-Сэхээгийн боомтоор улс хоорондын нүүрс тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол-Хятадын хамтарсан “Тавантолгой Шин” ХХК-д олгов. Мөн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу “Тавантолгой транс” ХХК-иас бүрдүүлж ирүүлсэн материалыг хянан судалж, тус компанид Тавантолгойн уурхайгаас Гашуун сухайт-Ганц модны чиглэлд нүүрс тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

Монгол-Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц модны боомтоос Тавантолгойн нүүрсний уурхай хүртэлх 257 км, Шивээ хүрэн-Сэхээгийн боомтоос Нарийн сухайтын нүүрсний уурхай хүртэлх 58,8 км, Баянхошуу-Өвдөгийн боомтоос Монгол Улсын Тамсагийн газрын тосны орд хүртэлх 225 км авто замын маршрутыг тогтоон баталлаа.

Улаанбаатар-Улаан Үүд-Улаанбаатарын чиглэлд улс хоорондын зорчигч тээврийн байнгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг “Нью Жуулчин Турс” ХХК-д олгож энэ чиглэлд улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн байнгын үйлчилгээг нээв.

Импортоор оруулж ирэх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан 24 буюу түүнээс дээш суудалтай, 48 буюу түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, үйлдвэрлэснээс хойш 5 хүртэл жилийн доторх автобус, троллейбусанд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулахгүй байх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв.

✓ *Дээрх хууль батлагдсанаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг үзүүлэх, стандартын шаардлага хангасан их багтаамжийн автобусны тоо нэмэгдэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нийслэлийн замын ачааллыг багасгах, байгал орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, үйлчилгээний соёл, чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой болох юм.*

2006 онд “Оношлогоо-аюулгүй тээвэр” гэсэн уриан дор техникийн хяналт, оношлогоонд тээврийн хэрэгслийг Улаанбаатар хотод 80 хувь, аймаг орон нутагт 90 хувьд

хүргэж хамруулах зорилт тавин ажиллаж байна. Сүүлийн 100 хоногт техникийн хяналт, оношлогоонд Улаанбаатар хотод 13852, орон нутагт 2395 нийтдээ 16247 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.

- ✓ *Тээврийн хэрэгслийг техникийн хяналт, оношлогоонд бүрэн хамруулснаар, стандартын шаардлага хангаагүйг нь замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх боломж бүрдэх учир түүний ашиглалтын улмаас хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа байгаль орчинд учруулж буй сөрөг үр дагавар багасах ач холбогдолтой юм.*

“Монгол Улсын Худалдаа, тээврийг дэмжих” Үндэсний семинарыг зохион байгуулав. Семинарын үеэр худалдаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлүүдийн талаар харилцан ярилцаж, худалдаа, тээврийг хөнгөвчилөх чиглэлээр зөвлөмж гаргав.

Индонезийн Жакарта хотноо болсон НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн Комисс (АНДЭЗНК)-ын 62 дугаар чуулганд Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл оролцлоо. Чуулганы бүгд хуралдаанаар Ази, Номхон далай (АНД)-н бүс нутгийн эдийн засаг, нийгмийн байдал, Сайд нарын дугуй ширээний ярилцлагаар дэд бүтэц, түүний дотор гамшгийн менежментийн дэд бүтцийг хөгжүүлэхэд бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай асуудлуудыг тус тус хэлэлцэв. Хуралдаанаар 2006 оны 11 дүгээр сарын 6-11-нд БНСУ-ын Пусан хотноо болох тээврийн асуудал эрхэлсэн сайд нарын уулзалтаар Транс Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах чиглэлээр ажиллахаар шийдвэрлэв. Мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудын худалдааны сайд нарын хурлыг 2007 онд Улаанбаатарт зохион байгуулахаар төлөвлөж буйг мэдээлж, хурлыг зохион байгуулахад Комиссын зүгээс дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хүсэв.

Дэлхийн улс орнуудын нийтлэг чиг хандлага болон ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглахтай холбогдуулан эдгээр ордуудыг холбосон төмөр замын шинэ сүлжээг байгуулах хөрөнгө оруулалт, өмчлөлийн эрх зүйн орчинг бий болгох, одоо байгаа төмөр замаар өмчийн бусад хэлбэрийн байгууллагууд төмөр замын тээврийн үйлчилгээ эрхлэх нөхцлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймд Төмөр замын тухай, Төмөр замын тээвэрлэлтийн тухай хуулиудын төслийг боловсруулаад байна.

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд ОХУ-ын Тээврийн сайд И.Е.Левитинтэй уулзаж хоёр орны зам, тээврийн салбарын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцож Оросын талаас Монголын төмөр замд хөрөнгө оруулах боломж, хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэгийг байгуулах тухай 1949 оны Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх, Монгол-Оросын ЗГХК-ын Тээврийн ажлын хэсгийг ойрын хугацаанд хуралдуулах зэрэг асуудлуудыг авч хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулж байгаа өөрчлөлтөөр нислэгийн чиглэлийг нэмж, Монголын нутаг дэвсгэр дээрх цэгийг Улаанбаатар, Ховд, Хятадын нутаг дэвсгэр дээрх цэгийг Бээжин, Шанхай, Хөх хот, Урумч, Тяньжин, Хайлаар, Харбин болон агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэх хилийн чанад дахь цэгийг Осака, Токио, Сөүл байхаар тохирсон болно.

БНХАУ-ын Бээжингийн чиглэлд гүйцэтгэх нислэгийн давтамж 6 байсныг 8 болгон нэмэгдүүлж, үндэсний агаарын тээвэрлэгчид Бээжин, Хөх хот руу тогтмол нислэг үйлддэг эрхтэй байсныг Шанхай, Урумчи, Тяньжин, Хайлаар, Харбинд тогтмол нислэг үйлдэж болохоор эдгээр цэгүүдийг нэмж Хятадын талтай тохиролцов. Мөн Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт зохих нэмэлт өөрчлөлтийг оруулах замаар нислэгийн чиглэлүүдийг нэмэгдүүлэх, үүнд хоёр улсын хил орчмын цэгүүдийн хооронд агаарын тээвэрлэлтийн харилцааг бий болгох, чиглэлээр ажиллаж байна. Үүнд ОХУ-ын нислэг хийх цэгүүдийн тоонд Новосибирск, Кемерово зэрэг хэтийн ирээдүйд нислэг хийгдэх бололцоотой хотуудыг нэмэх төлөвлөгөөтэй байна.

“МИАТ ХК” нь нойтон түрээсийн зарчмаар Итали Улсын “Blue Panorama” компаниас Боинг-767 агаарын хөлгийг авч зуны эд ачаалалтай үеийн богино хугацаанд Милан-Берлин-Москва-Улаанбаатар чиглэлд нислэг хийхээр төлөвлөж байгаатай холбогдуулан агаарын харилцааны зарим асуудлыг шийдвэрлэхээр ОХУ, Италийн холбогдох байгууллагатай хэлэлцэж байна. Тэрчилэн дотоодын нислэгт хувийн хэвшлийн компаниудын оролцох хүсэлтийг дэмжиж зохих зөвшөөрөл олгож 2-3 онгоц ойрын хугацаанд орж ирэхэд бэлэн болоод байна. Эдгээр онгоц дотоодын нислэг үйлдснээр

гадаадын жуулчдын болон дотоодын иргэдийн нислэгийн хэрэгцээг хангах хүчин чадал бий болох юм.

“Усан замын тээврийн тухай” Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”, “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг батлуулан мөрдүүлэв.

- ✓ *Эдгээр журмыг хэрэгжүүлснээр тэсэрч дэлбэрэх болон бусад аюултай ачаа, химийн бодисыг усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх үеийн аюулгүй байдал хангагдах, иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа усан замын тээврийн хэрэгслүүд нэгдсэн бүртгэл, дугаартай болж, усан замын тээврийн аюулгүй ажиллагаа, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нөхцөл бүрдэж байна.*

Аялал жуулчлалын салбарт:

Аялал жуулчлалд оролцогч бүх талуудын чадварлаг, мэргэжлийн үйл ажиллагаагаар салбарын амжилт тодорхойлогддог тул тэдгээрийг чадавхижуулах, мэдээлэлжүүлэх, мэргэшүүлэх зорилгоор 2006 оныг аялал жуулчлалын бүх нийтийн боловсролын жил болгон зарлаж холбогдох ажлууд хийгдэж байна.

Аялал жуулчлалын боловсролыг дэмжих жилийн хүрээнд улирал бүрт нэг дэд зорилттой ажиллаж байна.

2006 оны 1 улирал: Мэдээлэлтэй жуулчин

2006 оны 2 улирал: Инээмсэглэл аян

2006 оны 3 улирал: Тайван жуулчин

2006 оны 4 улирал: Мэргэшсэн жуулчлал

Жуулчдын сонирхлыг татах олон чухал арга хэмжээ Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдахаар төлөвлөгдөн зарлагдаж байгаа учир энэ 2006 он бол аялал жуулчлалын салбарын хувьд хамгийн олон жуулчин хүлээн авах таатай боломж бүрдээд байна.

Энэ онд зохиогдох аялал жуулчлалын арга хэмжээг Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойн хүрээнд зохион байгуулж байгаа бөгөөд энэ I улиралд аялал жуулчлалын чиглэлээр “Монгол наадгай -шагайн наадам”, Мөсний баяр”, “Говийн өглөө - Тэмээний баяр 2006”, “Сарлагийн баяр” зэрэг арга хэмжээг холбогдох аймгуудын нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж гадаад, дотоодын жуулчдыг өргөнөөр оролцуулсны дээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчиллаа.

ХБНГУ-ын Берлин хотноо /3 сарын 8-12/ зохиогдсон дэлхийн аялал жуулчлалын хамгийн том үзэсгэлэн ITB-2006-д аялал жуулчлалын компаниудыг зохион байгуулан оролцон Монгол орныг сурталчлав.

Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Австри Улстай аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээ байгуулав.

АНУ-ын ОУХА-тай хамтран “Аялал жуулчлалын тулгамдсан асуудлууд ба түншлэл” сэдэвт дугуй ширээний уулзалт, Тайваны Аялал жуулчлалын газартай хамтран зочид буудлын менежмент, хөтөч-тайлбарлагчийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх түр сургалтыг тус тус зохион байгууллаа.

Монгол орныг олон улсад сурталчилах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ танилцуулах, жуулчны байгууллагуудын үйлчилгээг сайжруулах талаар дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2006 оны I улиралд Монгол ирсэн жуулчдын тоо 53.9 мянгад хүрч өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар өссөн байна.

2005-2008 онд нийт 2 сая жуулчин хүлээн авах зорилт тавьж 2006 онд салбарын хүчин чадлыг 20 хувиар нэмэгдүүлж, 400000 жуулчин авах, шинээр 1500 ажлын байр бий болгохоор ажиллаж байна.

Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулав.

“Шуудангийн санхүүгийн үйлчилгээний нэгдсэн хэлэлцээр”, Дэлхийн шуудан холбооны дүрэмд өөрчлөлт оруулсан 7 дугаар протоколыг соёрхон батлууллаа.

Түлш, эрчим хүчний салбарт

Түлш, эрчим хүчний салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох бодлогын хүрээнд “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн” үзэл баримтлалыг боловсрууллаа.

“Шингэрүүлсэн шатдаг хийн хадгалалт, тээвэрлэлтийн үеийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа” сэдэвт анхдугаар зөвлөгөөнийг зохион байгууллаа. Хөдөө орон нутагт шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг нэмэгдүүлэх, түлшээр хомсдолтой говийн бүсийн аймгуудад нэн яаралтай хийн барилга байгууламжийг барих шаардлагатай уялдуулан 2007 онд Дундговь аймагт хийн цэнэглэх станц барихаар төлөвлөсний дагуу урьдчилсан тооцоо судалгааг хийлээ.

Нүүрсний хийгээр ажиллах 200 кВт чадалтай бичил станцыг Улаанбаатар хотод барьж туршилтын ажлыг зохион байгуулж байна. Туршилтын явцад Налайх, Багануур, Шивээ-Овоогийн уурхайн нүүрсийг хийжүүлсэн бөгөөд нүүрсний чанараас онцын хамааралгүйгээр хийжүүлэлт явуулж болохыг лабораторийн химийн шинжилгээгээр тогтоогоод байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Түгээх сүлжээний алдагдал бууруулах” төслийн хүрээнд Улаанбаатар хотын цахилгаан түгээх сүлжээ, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар аймгийн төвийн цахилгаан түгээх сүлжээг шинэчлэн сайжруулахаар төлөвлөгдсөн. Үүнээс Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар аймгийн төвийн болон Улаанбаатар хотын Баянгол, Чингэлтэй дүүргийн ЦТС-ний шинэчлэлтийн ажлыг дуусгасан бөгөөд Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Налайх дүүргүүдийн гэр хорооллын цахилгаан түгээх сүлжээний шинэчлэлийн ажил үргэлжлэн явагдаж байна.

Говь-Алтай, Завхан аймгийн төв, ойролцоох 8 сумдыг цахилгаан эрчим хүчээр хангах Тайширын УЦС, баруун гурван аймгийг цахилгаан эрчим хүчээр хангах Дөргөний УЦС-ын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Дөргөний УЦС-ын суурилагдсан хүчин чадал нь 12 МВт, жилдээ 38 сая кВтцаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх учир ОХУ-аас импортоор цахилгаан авч байгаа /жилдээ 40 орчим сая кВтцаг/ баруун 3 аймгийн хэрэглээг дотоодоосоо хангана. Ингэснээр баруун бүсийн эрчим хүчний системийг өөрийн, найдвартай эх үүсвэртэй болгож, эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг баталгаажуулах стратегийн ач холбогдолтой юм.

Богдын голын УЦС-ын шинэчлэлийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Уг УЦС нь 2 МВт-ын хүчин чадалтай, жилдээ 6.5 орчим сая кВтцаг цахилгаан үйлдвэрлэж, Завхан аймгийн төвийн эрчим хүчний хангамжийг дулааны улиралд найдвартай хангах бололцоотой болно.

Баруун бүс нутгийн эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагааг хангах үүднээс импортын цахилгаан эрчим хүчний гэрээг шинэчлэн, тарифыг бууруулах, улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэн 903.8 сая төгрөг болгох, импортын цахилгаан эрчим хүчний төлбөрөөс хамааран хэрэглэгчдийг цахилгаанаар хязгаарладаг асуудлыг бүрэн зогсоох арга хэмжээ авсан.

Улсын төсвийн 2006 оны төлөвлөгөөнд нийт 18.2 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган батлуулж, шинээр эхлэх Увсын Алтанцөгц-Ховд, Хэнтийн Биндэр-Батширээт, Сүхбаатарын Халзан-Баяндэлгэр, Дөргөний УЦС-Дөргөн сум, Говь-Алтайн Есөнбулаг-Шарга, Дундговийн Баянжаргалан-Өндөршил, Дорнодын Чойбалсан-Сэргэлэн зэрэг 8 ЦДАШ, дэд өртөөний зураг төслийн гүйцэтгэчийн тендерийг зарлан дүгнэж, гэрээг байгуулан зураг төслийн ажлыг эхлээд байна. Дундговийн Хулд-Өлзийтийн 15кВ-ын ЦДАШ, дэд өртөөний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Эрчим” ХХК-г сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг эхлүүлэв. Увс аймгийн Улаангом-Зүүнговь-Малчин-Хяргас сумын 110 кВ-ын ЦДАШ, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар дэмжсэн шийдвэрийг гаргуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Хөдөөгийн малчин өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 48 мянган айл өрх нар, салхины цахилгаан эх үүсвэртэй болоод байна. Хөтөлбөрийг 2006 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа 16.0 сая ам.долларын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх тооцоо, судалгааг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд оруулахаар бэлтгэж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт

2006 оныг малын чанарыг сайжруулах талаар бодитой ахиц өөрчлөлт гаргах жил болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Малчдын идэвх санаачилгыг өрнүүлж өвөлжилт, хаваржилтыг зохион байгуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, аймаг, сумдад мал хамгаалах сан бий болгох, мал сүргийг эрүүлжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын үр дүнд 2006 оны эхний улирлын байдлаар төл бойжилт 99.3 хувьтай, малын зүй бус хорогдол өнгөрсөн оны мөн үеийнхээс 288.0 мянгаар цөөн байна.

Энэ жил 148.7 мянган га талбайд тарилалт хийнэ. Өнгөрсөн жилийн уриншдаа бүрэн тарилалт хийхийн тулд 25 мянган тн үр шаардлагатай байна. Улсын нөөц, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас тодорхой хэмжээний үр хаврын тариалалтад зориулж гаргана.

Энэ онд 2 тэрбум төгрөгийг шинээр услалтын систем барьж байгуулахад, 770.0 сая төгрөгийг хүүчин услалтын системийг сэргээн засварлахад, 100 сая төгрөгийг усны фондын судалгаа хийлгэхэд, 2 тэрбум төгрөгийг техникийн шинэчлэл хийхэд, мөн 2 тэрбум төгрөгийг хүнсний улаан буудай авч, түүгээр дамжуулан үрийн шинэчлэл хийхэд зориулна. Мөн Япон Улсаас КР-2 хөтөлбөрийн хүрээнд бага орлоготой фермерүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 3 орчим тэрбум төгрөгийн өндөр хүчин чадалтай техник орж ирнэ. Газар тариалангийн үйлдвэрлэлд 10 гаруй тэрбум төгрөгийг зориулна.

Хүн ам олноор төвлөрсөн хот, суурин, бүсийн төвүүдийн орчимд эрчимжсэн мал аж ахуйг санхүү, зээлийн бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд 2006 он гарсаар 71 иргэн, аж ахуйн нэгжид нийт 390.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод байна. Махны үйлдвэрлэл нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрчимжсэн аргаар үхэр, хонины мах үйлдвэрлэх” дэд хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх ажлыг эхлээд байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах вакцины 85 хувийг орон нутагт хүргэж хаврын улиралд хийдэг мал эмнэлгийн арга хэмжээг эхлүүлээд байна. Бүх аймгуудад шувууны томуу өвчнөөс сэргийлэх, мал сүрэг, иргэдийг хамгаалах талаар семинар өгч, гэрийн шувуудыг 100 хувь дархлаажууллаа.

Энэ жил бэлчээр усжуулалтад улсын төсвөөс зарцуулах хөрөнгийг өнгөрсөн оныхоос 2.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, инженерийн хийцтэй 533 худгийг сэргээн засварлаж, 180 худгийг шинээр гаргахаар аймгуудад хөрөнгийг хуваарилсан. Одоо бүх аймаг тендерээ зарлаж, дүгнэх ажлыг зохион байгуулж байна.

2006 оныг газар тариалангийн техник, технологийн шинэчлэлийн жил болгон зарлаж хуурай гандуу нөхцөлд нийцүүлсэн “Тариалангийн салбарт баримтлах технологийн шинэчилсэн зөвлөмж” боловсруулан тариаланчдын зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэн хэрэгжүүлж эхэллээ.

Техник шинэчлэлд Япон Улсын Засгийн газрын КР-1 төслийн хуримтлалын сангаас нийт 2.0 тэрбум төгрөг зарцуулж байгаа бөгөөд үүгээр худалдан авах техникийн тендерийг зарлан дүгнэв. Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” КР-2 төслийг “Санхүүгийн чадвар муутай фермерүүдэд дэмжлэг үзүүлэх” төсөл нэртэйгээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх асуудлыг Японы талтай тохиролцож 330 сая иенээр үр тарианы комбайн, том болон бага оврын трактор, хөдөө аж ахуйн бусад машин техникийг энэ онд авахаар тохирч, тендерийг нь Токио хотод зарлаад байна.

БНХАУ-ын буцалтгүй тусламжийн 20 сая юаниар 350 бага оврын тракторыг иж бүрдлийн хамт, нэг га-гийн усалгааны төхөөрөмж 100 ширхэг, 25 га-гийн усалгааны машин 50 ширхэг авах саналыг Хятадын талд тавьж шийдвэрлүүлэв.

Япон Улсын КР-2 төслийн хуримтлалын сангийн хөрөнгөөр 550 бага оврын трактор, иж бүрдлийн хамт нийтдээ 1000 шахам бага оврын трактор, иж бүрдлийн 6 дугаар сарын эхээр хүлээн авах бэлтгэл хийж байна.

- ✓ *Үүний үр дүнд малчид, иргэд өөрсдийн хүчээр бэлтгэх хадлан тэжээлийн хэмжээг 40.0 хувиар нэмэгдүүлж, байгалийн эрсдлийг даван туулах чадавхи сайжрах юм.*

Засгийн газрын хуралдаанд Монгол Улсыг Ази, Номхон далайн Хөдөө аж ахуйн инженер, машин механизмын төвийн гишүүнээр элсүүлэх тухай асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Энэ жил “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 25 хүлэмж, дуслын усалгааны систем 25, бага оврын трактор 8 иж бүрдлийг авахаар тендер зарлан дүгнэх гэрээ байгуулав.

Түүнчлэн аймгуудын агро парк, иргэдэд зориулан хүнсний ногооны үр 6.0 тонн, нийлэг хальсан хүлэмж, ногооны гар багаж, бордоо олгох ажлыг зохион байгуулж байна.

- ✓ Энэ онд нийтдээ 10.0 мянган га-д төмс тариалахаар төлөвлөж байгаагийн зэрэгцээ Швейцарийн Хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн “Монгол оронд төмсний үрийн чанарыг сайжруулах нь” төсөлтэй хамтран 6 аймагт чанар сайтай, ургац арвинтай төмсний үр үржүүлгийн ажлыг эхлээд байна.

Хөрсний чийг хаах, сүрлэн хучлага бий болгох зорилгоор одоогийн ашиглаж буй үрлүүр, сийрүүлүүр, үр тарианы комбайны ажлын эд ангийг шинэчлэн тоноглоход зориулан 300 ширхэг үрлүүр, 160 сийрүүл нийлүүлж, 200 комбайныг сүрэл хэрчих төхөөрөмжөөр тоноглож, 45.0 – 60.0 мянган га-д шаардагдах техникийн шинэчлэлт хийх арга хэмжээ авч байна.

Энэ хаврын тариалалтын бэлтгэлийг үндсэнд нь хангаад байна. Тариалалтад зориулж нутагшсан сайн чанарын 5000 тонн үр нийлүүлэх арга хэмжээ авч байгаагийн зэрэгцээ арилжааны банкуудаас сарын 1.6 – 1.8 хувийн хүүтэй 2.5 тэрбум төгрөгийн зээл олгох асуудлаар зарчмын тохиролцоонд хүрэв.

11 аж ахуйн нэгжтэй 3000 тонн махны нөөц бүрдүүлж, борлуулах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу махыг 102 дэлгүүрт борлуулж эхэллээ. Нийт хэрэгцээт махны 35 орчим хувийг энэхүү нөөцөлсөн махаар хангаж, гэрээний дагуу 2000 төгрөгөөр борлуулж байна.

2006 оны 2, 3 дугаар сард хийсэн яриа хэлэлцээрийн үр дүнд БНСУ-ын “КОЙКА” байгууллагын шугамаар 500.0 мянган ам.долларын “Худаг гаргах” төсөл болон Япон Улсын “ЖАЙКА” байгууллагын 2.0 сая ам.долларын “Мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх загвар аж ахуй бий болгох” төслийг ойрын хугацаанд хэрэгжүүлж эхлэхээр тохиролцлоо.

Хүнс, хөдөө аж ахуйн яам бусад яам, төрийн захиргааны байгууллагуудыг уриалж “Нэг ажилтан – нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг өрнүүлж ажилласны үр дүнд төрийн албан хаагч 70 хүн үр дүнгийн гэрээнээс гадуур 72 бүтээгдэхүүн санаачлан бий болгож түүгээрээ үзэсгэлэн гаргаж сурталчлав.

Харилцаа холбооны салбарт

“Цахим Засаглал” мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн шугамаар “Мэдээллийн технологийн архитектур, интерпрайз архитектурыг боловсруулах” төслийг эхэлж, Монгол Улс дахь судалгааны ажлыг зохион байгууллаа.

Цахим Засаглалыг хэрэгжүүлэх, төслүүдийг санхүүжүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор БНСУ-ын “RENOBOT” групптэй хамтран ажиллах санамж бичигт МХХТГ-ын төлөөлөгчид гарын үсэг зурж, хэрэгжүүлж эхлээд байна.

Хөрш орнуудын Засгийн газар, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгч компаниуд, Олон улсын холбогдох байгууллагуудтай зохих яриа хэлцэл явуулж гэрээ байгуулсны үр дүнд манай улс руу орж ирж буй интернэтийн 1Мбит/сек.-ийн үнийг жилийн мөн үеийнхтэй харьцуулахад даруй 10 дахин бууруулж дотоодын интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд 1Мбит интернэтийн урсгалд 400 ам.доллар төлөх, эцсийн хэрэглэгчид хямд бөгөөд чанартай, өндөр хурдны үйлчилгээ хүртэх, өндөр хурдны өргөн зурвасын технологиос сонголт хийх боломжийг бүрдүүлээд байна.

Хөдөлгөөнт холбоо (CDMA 450), сансрын холбоо (VSAT)-ыг орон нутагт нэвтрүүлж хөгжүүлэх төслийг сумдад хэрэгжүүлэх асуудлаар Харилцаа холбооны зохицуулах хороо /ХХЗХ/-оос “JM International” компанид тусгай зөвшөөрөл олгоод байна.

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Цахим Монгол” хөтөлбөрт тусгагдсаны дагуу төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, иргэдэд учруулж буй хүндрэл, чирэгдлийг бууруулах, төрөөс иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, иргэний бичиг баримтуудыг нэгтгэж орчин үеийн дэвшилтэд хэлбэрт оруулах зорилгоор “Монгол Улсын иргэний цахим үнэмлэх” төсөл боловсруулаад байна.

“Монгол Улсад утасгүй суурин холбооны “WLL” технологийг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл”-ийг батлууллаа.

Аймгуудийн төвд Интернэт үйлчилгээний төв байгуулах ажлыг бодлогоор дэмжих ажлын хүрээнд “Теггаох” компанитай санал солилцож, тэдний талаас тавьсан саналын дагуу 2 аймгийн төв, 2 сумын төвд “WIMAX” туршихаар тохиролцоонд хүрэв.

Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй сумдад телевизийн олон суваг хүлээн авч, дахин дамжуулах тоног төхөөрөмж суурилуулах төслийн хүрээнд санхүүгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэснээр орон даяар 373 сум, суурин газарт телевизийн олон суваг хүлээн авч, дахин дамжуулах тоног төхөөрөмж нийлүүлж суурилуулах төслийн тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг эхлэн зарлаад байна.

“Монгол Улсын баруун, хойд чиглэлийн шилэн кабелийн сүлжээ байгуулах” төслийн нарийвчилсан зургийг гаргаж, дамжуулах байгууламжийн суурилуулалтын төслийг эхлүүлээд байна.

Дашинчилэн-Булганы шилэн кабелийн дамжуулах сүлжээ байгуулах төслийн хүрээнд Дашинчилэнд суурилуулсан ZTE компаний S380 төхөөрөмжөөр тоон радио релейний NMS сигналыг МЦХ ХК-ний Дамжуулах байгууламжийн сүлжээний төв дээр хянаж, удирдах ажлыг гүйцэтгэж дууссан бөгөөд тоног төхөөрөмжүүдийг түрээслэх хөрөнгө оруулалтын хэмжээг тооцож, МХХХТ-д хүлээлгэн өглөө.

Цахим Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Бүх нийтийн компьютержүүлэлт хөтөлбөр”-ийн компьютерийн үзэсгэлэн худалдааг Налайх, Багануурт дүүрэгт зохион байгууллаа. Уг хөтөлбөрийн хоёрдугаар үе шатны арга хэмжээг зохион байгуулж байна.

Төрийн байгууллагуудыг вэбтэй, ажилтан бүрийг цахим шуудангийн хаягтай болгох төслийн хүрээнд Төрийн байгууллагуудад суурилуулах “Живаа” агуулгын удирдлагын системийг хянах хяналтын програм, төрийн байгууллагуудын вэбийн нэгдсэн лавлах порталыг тус тус боловсруулж ашиглахад бэлэн болгоод байна.

Украин улсаас худалдан авч хөдөөгийн холбоонд ашиглаж буй тоон радио релейны шугам үйлдвэрлэгч компанитай цаашид хамтран ажиллах чиглэлээр Санамж бичигт гарын үсэг зурлаа.

Шилэн кабелийн дамжуулах төхөөрөмжийн SU67AC 4ш модулийг “Marconi” компаниас авч МЦХ ХК-д хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулав.

2005 онд хэрэгжүүлсэн “Төрийн ордны утасгүй сүлжээ” төслийг 3 дугаар сарын 07-нд Улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан.

Тав. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ТАЛААР

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Ховд, Баян-Өлгий аймгийн зааг нутаг дахь Мөнххайрхан уул, Архангай, Өвөрхангай аймгийн зааг нутаг дахь Орхоны хөндийг байгалийн цогцолбор газрын ангиллаар, Увс аймгийн нутаг дахь Тэсийн голын сав нутгийг байгалийн нөөц газрын, Хөвсгөл аймгийн нутаг дахь Даян дээрхийн орчмын газрыг дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авах тухай асуудлыг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулав.

✓ *Энэ 4 хэсэг буюу 520.0 мянган га нутгийг улсын тусгай хамгаалалтад авснаар Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн 13.7 хувь буюу 21.5 сая га нутаг тусгай хамгаалалттай нутгийн сүлжээнд оров.*

Байгаль хамгаалагчдын хариуцах талбайн норматив шинэчлэгдсэнтэй уялдуулан Монгол Улсын бүх сумын бүсийн ангиллын жагсаалт, Тусгай хамгаалалттай газар нутагт ажиллах байгаль хамгаалагчдын хариуцах талбайн нормативыг шинэчлэн батлав.

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газраар батлуулав.

Байгалийн нөөц баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагааны журам, нөхөрлөлөөс сумын Засаг даргатай байгуулах гэрээний загвар, нөхөрлөлийн гэрчилгээний загварыг батлав.

Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр нь урамшуулах тухай журмыг баталж, улсын бүртгэлд бүртгүүлэв.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний комиссын ажиллах журам, нарийвчилсан үнэлгээ хийх, мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнд эрх олгох, хүчингүй болгох, хянан магадалгаа хийх журам, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий ба нарийвчилсан үнэлгээ хийх аргачилсан заавар зэрэг нийтээр дагаж мөрдөх шийдвэрүүдийг баталгаажуулав.

Гол мөрний сав газрын зөвлөлийн дүрэм, усны тоо бүртгэлийн журам, усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх, үзүүлэлт хөтлөх, Ус ашиглуулах тухай мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох, усны нөөцийн ашиглалтанд хяналт тавих журмуудыг боловсруулан батлахад бэлэн болгов.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаарх сургалтыг бүх аймаг, сумыг хамруулан 4 бүсэд зохион байгуулав.

Нийслэл хотын дэвсгэр нутаг дахь байгалийн нөөц баялгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг хангахтай холбогдсон 3 жилийн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан нийслэлийн Засаг даргатай хамтарч боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

Ой хээрийн түймрээс хамгаалах, орчны бохирдлыг цэвэрлэх, ойн нөөцөө нөхөн сэргээх чиглэлээр зохиох “Байгаль орчин-бодит ажил” сэдэвт сарын ажил зохион явуулахаар тушаал гаргаж, ажлын удирдамж, болзол гарган 4 дүгээр сарын 20-ноос энэ ажлыг эхлэв.

Зургаа. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН ТАЛААР

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан.

Дайны байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, 2000-2004 онд батлагдсан Монгол Улсын хуулиудад дайны байдлын үед үйлчлэлийг нь зогсоох, хязгаарлах, нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын төслийг боловсруулав.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, 5 дугаар сард багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар бэлтгэж байна.

2006 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах иргэдийн тоог болон цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын төлбөрийн хэмжээ, 2006 онд хугацаат цэргийн болон гэрээт албанд элсүүлэх иргэдийн тоо, цэрэг халах, татах хугацааг тогтоолоо.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Монгол Улсын Зэвсэгт хүчний 85 жилийн ойд зориулан “Монгол цэрэг-800” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулан явуулав.

Украин, Беларусь Улстай зэвсэглэл, техникийн шинэчлэл, цэргийн боловсон хүчин, Батлан хамгаалахын удирдлагын айлчлал, сургалт зэрэг асуудлаар санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлов.

Монгол Улс, АНУ-ын хамтын ажиллагааг зохицуулах Батлан хамгаалах яамдын Удирдах зөвлөлийн анхдугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Монгол Улсын Батлан хамгаалах яаманд ХБНГУ-ын Холбооны Батлан хамгаалах яамнаас үзүүлсэн 195.945 еврогийн буцалтгүй тусламжийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг Зэвсэгт хүчний клиникийн төв госпитальд хүлээлгэн өгснөөр Батлан хамгаалах салбарын нийт ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн асуудалд шийдвэрлэхэд зохих дэмжлэг болсон.

“Цэргийн орон сууц 2010” хөтөлбөрийг баталж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 29 айлын орон сууцыг ашиглалтад өгч, 48 айлын орон сууцны барилгыг үргэлжлүүлэн барих, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт 420 айлын орон сууц барих, Дархан хотод байгуулж буй цэргийн ангийн офицер ахлагч нарт зориулан 100 орчим айлын орон сууц барих, засварлан гүйцээх, Зэвсэгт хүчний 123, 016 дугаар ангиудын офицер, ахлагч нарт зориулж тус бүр “40 айлын гэр хороолол” төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, бэлтгэлийг хангаж байна.

Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг “Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин ба бэлэн байдал” сэдвээр амжилттай зохион байгуулав.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн Ү ээлжийн бүрэлдэхүүнийг ҮI ээлжийн бүрэлдэхүүнээр солих ажиллагааг осол аварггүй амжилттай зохион байгууллаа. Цэргийн багийн ҮI ээлжийн бүрэлдэхүүн, Олон үндэстний дивиз /төв-өмнөд/-ийн штаб байрлах “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна.

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа Сургалтын хөдөлгөөнт багийн Ү ээлжийн бүрэлдэхүүн Афганистаны үндэсний армийн артиллерийн салбаруудын офицер, ахлагч, цэргүүдийг сургах, артиллерийн зэвсэглэлд засвар үйлчилгээ хийх үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг бааз, Тусгай шүүх дээр байрлан үүрэг гүйцэтгэж байна.

Косово дахь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд дэмжлэг үзүүлж буй олон үндэстний дивизийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэсэн цэргийн багийн бүрэлдэхүүн төр засаг, цэргийн командлалаас өгсөн үүрэг даалгаврыг амжилттай биелүүлэв.

“Хааны эрэлд-2006” Олон улсын энхийг сахиулах ажиллагааны дунд шатны - төлөвлөлтийн бага хурлыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг хуралд АНУ-ын Номхон далайн цэргийн командлал, АНУ-ын дэлхийн энхийг дэмжих ажиллагааны сан, Фижи, Тога, Тайланд улсын төлөөлөгчид оролцлоо.

- ✓ *Тус хурлаар энэ оны 8 дугаар сард явагдах “Олон улсын төлөвлөлтийн өргөтгөсөн баг”-ийн КШС, “Хааны эрэлд-2006” олон улсын энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургуулийн зохион байгуулалт, төлөвлөлт, оролцох бүрэлдэхүүн, ар талын хангалтын бэлтгэл ажлын талаар хэлэлцэж, урьдчилсан тохиролцоонд хүрэв.*

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаар

2006 онд гамшиг, ослын улмаас байгаль экологи, эдийн засаг, ард иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөнд 691,4 сая төгрөгийн хохирол учирсан ба гамшгийн үед аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд орон нутгийн мэргэжилийн байгууллагын аврагч, иргэдээс давхардсан тоогоор 5 мянга гаруй хүн, мянга гаруй автомашин ажиллаж, шуурхай ажиллалаа.

Шувууны аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дэлгэрэнгүй судалгаа гаргаж, тэжээвэр шувууг вакцинжуулалтад бүрэн хамруулах, орон нутагт шувууны өвчлөл, үхэл гарсан тохиолдолд тухайн орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудад яаралтай мэдээлж, өвчлөл гарсан тохиолдолд хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авах, шувууны томуу, томуугийн цар тахал өвчин гарсан үед хэрэглэх лабораторийн багаж, тоног хэрэгсэл, эм бэлдмэл, вакцин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийг бий болгох, эрүүл мэнд, хүнс хөдөө аж ахуй, онцгой байдал, хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнууд зэрэг өртөмтгий бүлгийн хүн амыг хүний томуугийн вакцинаар дархлаажуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна.

2006 оны 4, 5 дугаар сард тал, хээрийн нутгаар салхи ширүүсч шороон болон цасан шуурга шуурч цаг агаар тогтворгүй байх төлөвтэй байгаа учраас Засгийн газар албан даалгавар гарган ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, түймрээс урьдчилан сэргийлэхэд шаардагдах зардлыг бодитойгоор тогтоож, санхүүжүүлэх эх үүсвэрийг тогтоох, морин эргүүлийг нутгийн иргэд, цэргийн дүйцүүлэх алба хаагчдаас бүрдүүлэн тодорхой нутаг дэвсгэр хариуцуулан ажиллуулах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийх, тэмцэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай шатахуун, хүнс, хувцас, материал хэрэгслийн нөөц бүрдүүлэх, түймэр гарсан үед ажиллах үүрэг бүхий анги, отряд, салбарын бэлэн байдлыг хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Улсын нөөцийн өвс, тэжээлийн хадгалалтын байдалд судалгаа хийж чанар байдлыг нь үндэслэн үнэ бууруулан худалдах ажлыг зохион байгуулж байна.

Үр тарианы таримлын нутагшсан сортын үрийн олдоц муу байгааг харгалзан чанартай үрээр тариаланчдыг хангах зорилгоор ОХУ-аас 2000 тонн Алтайский-50 сортын улаанбуудайн үрийг импортоор худалдан авах ажлыг зохион байгуулж байна.

Долоо. ГАДААД БОДЛОГЫН ТАЛААР

Төрийн гадаад бодлогын нэгдмэл, залгамж чанарыг ханган, улс орны тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн, бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг бүх талаар хөгжүүлэхэд ач холбогдол өгч ажиллалаа. ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровын айлчлал/2006.03.20/-ын үеэр хоёр улсын дээд, өндөр хэмжээний яриа хэлэлцээ, айлчлалын давтамжийг цаашид хадгалах, харилцааны эрх зүйн үндсийг шинэчлэх, эдийн засгийн, ялангуяа уул уурхай, ашигт малтмалын салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх, олон улсын талбарт илүү ойр дотно хамтран ажиллахаар тохирлоо.

2006 онд Монгол-Хятадын сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлж, дээд, өндөр хэмжээний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, 2005 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрийн айлчлалын үеэр тохиролцсон асуудлуудыг ажил хэрэг болгох талаар хоёр тал хамтран ажиллаж байна.

Монгол Улсаас АНУ, Япон, Герман, БНСУ, мөн Европын Холбоотой, тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байна.

АНУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, саяхан болсон хоёр талын Зөвлөлдөх уулзалтаар/2006.02.23/ харилцааг өргөжүүлэх тодорхой асуудлуудыг ярьж тохиров. Мянганы Сорилтын Сангийн шугамаар өргөн барьсан төслүүдийг батлуулах, холбогдох гэрээ хэлэлцээрийг аль болох ойрын хугацаанд байгуулах чиглэлээр Мянганы Сорилтын Корпорац-тай хамтран ажиллаж байна.

- ✓ *Иж бүрэн түншлэлийн удирдах зарчмуудыг тусгасан суурь баримт бичиг боловсруулж байгуулах асуудлаар зарчмын хувьд тохирсон. МСК-ын Монголыг хариуцсан захирал болон экспертүүдийг урьж манай төслүүдэд үнэлгээ өгөх асуудлыг ярилцаж байна/*

Монгол Улсын Ерөнхий сайдын Япон Улсад саяхан хийсэн айлчлалын/2006.03.26-30/ үеэр Монгол-Японы иж бүрэн түншлэлийг илүү бодитой, тодорхой хамтын ажиллагааны түвшинд хүргэхээр тохирч, зээл, тусламжийн шинэ хэлэлцээрүүдийг байгууллаа.

- ✓ *Монгол Японы Иж бүрэн түншлэлийг бодитой шинэ шатанд гаргахаар тохиролцож, шинэ шатны зорилт, тодорхой чиглэлүүд, арга хэмжээнүүдийг хэлэлцэн уг асуудлаар Хамтарсан мэдэгдэл гаргав. Айлчлалын үеэр жижг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах зориулалтаар 26 сая ам.доллартай тэнцэх 2 шаттай иенийн зээлийн хэлэлцээр гарын үсэг зурж, 2.2 сая ам.долларын Хүнсний буцалтгүй тусламж авахаар хэлэлцээр байгууллаа.*

БНСУ-тай бие биеэ нөхсөн хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байна. Удахгүй болох БНСУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын/2006.05.07-10/ үеэр хоёр орны харилцааны түвшинг “сайн хөршийн, найрамдал, хамтын ажиллагааны түншлэл” болгон шат ахиулахаар хамтран ажиллаж байна.

- ✓ *Айлчлалын үеэр Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын Удирдлагын тохиролцооны гэрээ байгуулна. Мөн яамд хооронд түлш эрчим хүч, барилга, хот байгуулалт, зам тээвэр, аялал жуулчлал, ХАА-н чиглэлээр хамтын ажиллагааны баримт бичиг байгуулахаар ажиллаж байна.*

БНСУ, Дани, Финланд, Норвегийн Вант Улс-тай тогтоосон харилцааг парламентын болоод бусад салбарт урагшлуулахад МУ-ын УИХ-ын даргын хийсэн албан ёсны айлчлал/2006.02.28-03.08/ ач холбогдолтой болсон.

Европын Холбоо, түүний гишүүн орнуудтай хамтын ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлж, шинэ агуулга хэлбэрээ баяжуулахыг зорьж байна. 2006 оны 6 дугаар сард тус байгууллагын удирдлагыг Монголд айлчлуулж, Монгол-ЕХ-ны хамтарсан хорооны ээлжит хурлыг зохион байгуулахдаа тус Холбоотой байгуулах Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах асуудлыг урагшлуулах, ЕХ-ны мөрддөг “зах зээлийн бус орнуудын жагсаалт”-аас Монгол Улсыг гаргах зэрэг хамтын ажиллагааны олон асуудлыг ярилцаж шийдэхээр бэлтгэж байна.

Ази-Номхон далайн орнуудтай хоёр болон олон талын хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлд тодорхой зорилго тавин ажиллаж байна. Тухайлбал, Япон, Австрали, Малайз, Бруней улсаас өндөр хэмжээний төлөөлөгч айлчлуулах, Энэтхэг, Вьетнам зэрэг оронтой Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг зохион байгуулахаар ажиллаж байна. АПЕК, АСЕМ, Зүүн Азийн уулзалт зэрэг бүс нутгийн олон талт хамтын ажиллагааны механизм, байгууллагад элсэн орох чиглэлээрх үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.

- ✓ *Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага/АПЕК-/д 2007 оноос, Ази-Европын уулзалт/АСЕМ/-д 2006 онд, 2005 онд бий болосн*

Зүүн Азийн хамтын нийгэмлэгт цаашдаа элсэх асуудлаар хоёр болон олон талын хүрээнд ажиллаж байна.

Монгол Улсаас НҮБ-тай хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа нь манай улсын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд эн тэргүүнд чиглэж байна. НҮБ-аас 2007-2011 онд манай улсад үзүүлэх тусламжийн ерөнхий хүрээг тодорхойлсон баримт бичгийг/2006.03.01/ байгууллаа. Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн урт хугацааны стратеги боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Энэ нь Монголын хөгжлийн хэтийн зорилтуудыг манай түншүүдэд илүү тодорхой болгож, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой.

Ардчилалыг шинээр буюу сэргээн тогтоосон орнуудын олон улсын ү бага хурлыг даргалагч орны хувьд түүний шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, 2006 оны намар Катарын Доха хотноо болох VI бага хуралд зохих бэлтгэлийг хангаж оролцохоор ажиллаж байна.

Хилийн чанадад иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зорилтын хүрээнд тэдний зорчих, хөдөлмөр эрхлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахад өөрийн болон гадаадын төрийн бус болон хүний эрх, өмгөөлөл, нотариатын байгууллагуудыг өргөнөөр оролцуулах арга хэмжээг авч байна. Хилийн чанад дахь консулын төлөөллийг бэхжүүлэх үүднээс өргөмжит консулын хэд хэдэн төлөөллийг шинээр томиллоо. Визний журмыг хөнгөвчлөх талаар бусад оронтой яриа хэлцээ явуулж байна.

- ✓ *Словак, Литва улсад, мөн АНУ-ын Сакрамент хот, Туркийн Антала болон Самсун хотод ӨКГ байгуулсан. Монголын дипломат болон албан паспорттай иргэд Энэтхэгт 2006 оноос визгүй зорчдог болсон. Бразиль, Лаос, Тайландтай иргэд визгүй зорчих хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.*

2006 он бол Их Монгол Улс байгуулагдсаны 800, Монгол Улс НҮБ-д элссэний 45, Монголын дипломат алба үүсэн байгуулагдсаны 95 жилийн ой тохиож буй онцлогтой жил юм. 800 жилийн ойн хүрээнд гадаадаас өндөр, дээд түвшний төлөөлөгчдийг айлчлуулах, хоёр талын болоод олон талын хамтын ажиллагаагаа бүхий л боломжоор урагшлуулах, Монгол орноо дэлхийн ард түмэнд сурталчлан таниулах замаар олон улсын хэмжээнд нэр хүндийг нь өсгөх зэрэг дорвитойхон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд манай Засгийн газар онцгой анхаарч ажиллаж байна.

- ✓ *БНСУ-ын Ерөнхийлөгч, Чехийн Ерөнхийлөгч, Япон болон Энэтхэгийн Ерөнхий сайд, Нидерландын Ханхүү, Британийн хунтайж, БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга, Германы Бундестагийн Ерөнхийлөгч, Малайз, Австрали, Япон, Брунейн ГХ-ийн сайд, ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал зэрэг өнөдөр албаны хүмүүсийг айлчлуулахаар ярилцаж байна/.*

Дээрх ойг тохиолдуулан Монгол орноо гадаадад өргөнөөр сурталчилан таниулахад чиглэсэн тодорхой ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Австрид Монголын соёлын өдрүүд зохион “Чингис хаан ба түүний өв” үзэсгэлэнг гаргаж, үндэсний урлагийн тоглолтыг ч бусад орнуудад үзүүлж байна. Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг зохицуулах үндэсний зөвлөл үйл ажиллагаагаа эхлээд байна.

Мөн Гадаад бодлогын ээлжит хөх номыг монгол, англи хэлээр гаргаж байна. Сүүлийн үед гадаадын нэр хүндтэй хэвлэлийн төлөөлөгч олонтаа ирж манай орны талаар сурвалжлага хийж байгаа бөгөөд 6 дугаар сарын сүүлээр гэхэд л гадаадын 50 гаруй сурвалжлагчид ирэхээр төлөвлөж байна.

- ✓ */International Herald Tribune, Washington Post, Forbes, Ёмуури, Foreign Affairs, CNBC, CQ weekly, Euromoney зэрэг дэлхийд нэртэй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид ирж сурвалжлага хийсэн.*

Найм. ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ТАЛААР

Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай”, “Хил хамгаалах байгууллагын цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлийн норм батлах тухай”, “Орон сууц

шилжүүлэх тухай”, “Гадаад паспортыг шинээр хэвлүүлэх зардалд зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хөрөнгө гаргуулах тухай”, “Архив албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай”, “Хөрөнгө шилжүүлэх тухай /Эрх зүйн мэдээллийн 28 байгууллагыг холбосон физик холболтыг Тагнуулын ерөнхий газрын Төрийн холбоонд шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

УИХ-ын шинэчилсэн найруулгын төсөл, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, нөхөн олговор олгох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай зэрэг 10 хуулийн төсөл, “Монгол Улсын шүүгчийн зэрэг дэвийн журам батлах тухай”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба хашиж байсан П.Очирбатын зарим хангамжийн тухай” зэрэг УИХ-ын 7 тогтоолын төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Хадгаламжийн даатгалын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ази, номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага /APSCO/-ын конвенцийг соёрхон батлах тухай зэрэг хуулийн төсөл, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай”, “Шилжүүлэн зарцуулах эрх олгох тухай” зэрэг УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгосон.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам БНУУ-ын Хууль зүйн яам хоорондын хамтын ажиллагааны протоколд байгууллаа.

- ✓ *Уг протоколын хүрээнд Унгар улсад боловсрон хүчин бэлтгэх, мэргэжилтэн солилцох, туршлага судлах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг нааштай боломжууд бүрдээд байна.*

Шведийн Свенка институттэй хамтран “Хүнийг хил дамнуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалт-семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулж байна.

- ✓ *Уг сургалт-семинарийн зорилго нь хүн хил дамнуулан худалдаалах асуудалд анхаарал, түүнтэй хэрхэн тэмцэх талаар бусад орны арга барил, туршлагаас суралцаж, өөрийн орны нөхцөлд нийцүүлэн хэрхэн хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцоход оршиж байсан бөгөөд цагдаа, прокурор, шүүгч, хилийн цэрэг, иргэний бүртгэл мэдээлэл, гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид зэрэг 200-гаад хүн оролцлоо.*

“Сургагч багш нарын хичээл заах болон сургалт зохион байгуулах арга зүй”, “Танхайн гэмт хэргийн зүйлчлэл”, “Харуул, хамгаалалтын ажилтан нарт”, “Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”, “Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, прокурорын туслах ажилтан, өмгөөлөгч, нотаратчийн туслах нар зориулсан” зэрэг сэдэвчилсэн сургалтууд болон аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт-семинарыг тус тус зохион байгуулав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Булган аймаг дахь хорих 439 дүгээр ангийг жирийн дэглэмтэй төвлөрсөн хорих анги болгон өөрчлөн зохион байгууллаа.

Шийдвэр гүйцэтгэлийн мөнгөн дүнгийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх, гүйцэтгэгч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Дорноговь аймагт 1, Дорнод аймагт 2, Сэлэнгэ аймагт 1, Хэнтий аймагт 1, Хөвсгөл аймагт 1 тойрог нийт 6 тойрог шинээр нэмэв.

НҮБ-ын Хүүхдийн сан /ЮНИСЕФ/-тай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд насанд хүрээгүйчүүдийн хорих байрыг ашиглалтад бүрэн оруулсан.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргийн талаарх 14049 гомдол, мэдээлэл хүлээн авч, 4423-д нь эрүүгийн хэрэг үүсгэж, 5345-ыг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 2373-г захиргааны арга хэмжээ авч, 1406-г харъяаллын дагуу шилжүүлэх зэргээр нийт 13547 гомдол шийдвэрлэн, 4473 хэрэгт хэрэг бүртгэлт явуулж, түүнээс 3613 хэргийг

шийдвэрлэж, 3126 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, түүнээс 2036 хэргийг шийдвэрлэж, түүнчлэн урьд онуудын 475, энэ оны 579 гэмт этгээд нь тогтоогдоогүй байсан хэргийг нөхөн илрүүлсэн.

Засгийн газрын 2005 оны 65 дугаар тогтоолын дагуу “Иргэний бүртгэл, гадаад паспорт хяналтын нэгдсэн сүлжээ” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сүлжээнд ашиглагдах бүх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авч Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албанд хүлээлгэн өгөөд байгаа бөгөөд Замын-Үүд болон Алтанбулаг, Сүхбаатарын шалган нэвтрүүлэх боомт дээр нэгдсэн сүлжээнд ашиглагдах “Весат” системийг суурлуулж дуусгалаа.

Газрын тосны хайгуул, олборлолт, нүүрсний экспорт, усан цахилгаан станцын тоног төхөөрөмжлөл нэвтрүүлэх зориулалтаар Монгол Хятадын хилийн Шивээхүрэн, Гашуунсухайт, Бичигт, Баянхошууны боомтуудыг байнгын ажиллагаанд шилжүүлж, Бургастай боомтын ажиллах хугацааг уртасгалаа.

Улсын хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдсэн Дорноговь аймгийн Эрдэнэ сум дахь Хилийн 0129 дугаар ангийн шинэ цогцолборыг 2005 оны 11 дүгээр сард хүлээн авч, ангийг шилжүүлэн байрлуулж, Ховд аймгийн Үенч сум дахь Хилийн 0130 дугаар ангийн Соёлын төв, спорт заалны цогцолборыг ашиглалтад оруулж, Завхан аймгийн Тэс сум дахь Хилийн 0277 дугаар ангийн штабын барилгыг шинээр бариулж, ашиглалтанд орууллаа.

Монгол Улсын хууль тогтоомж, стангартын хэрэгжилтийг хангуулах зорилтын хүрээнд Давхардсан тоогоор 2619 байгууллага аж ахуйн нэгж, 3701 цэг байгууламж, 43502 иргэнийг хамруулан шалгалт хийж, 10946 зөрчил илрүүлж, 696.8 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоосны 60.2 сая төгрөгийг барагдуулаад байна.

Зөрчил гаргасан байгууллага, албан тушаалтан, иргэдэд нийт 14.1 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, үүнээс 80.8 % буюу 11.4 сая төгрөгийг барагдуулсан.

Тухайлбал, нийгмийн хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг 76 аж ахуйн нэгжид 659 иргэнийг хамруулан шалгасны 59.2 хувь нь төлөвлөгөөт, 40.8% нь төлөвлөгөөт бус буюу өргөдөл гомдлын дагуу хийгдсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 31 заалт бүхий 9 акт үйлдэж, 22 заалт бүхий 7 албан шаардлага өгч биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Нийтдээ 12809.7 мянган төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын зөрчил илрүүлж, 1861.3 мянган төгрөгийн НДШ-ийн нөхөн төлбөр төлүүлэх арга хэмжээ авч, нийт 14820.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна. Нийгмийн халамжийн сангийн зөрчилд 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт үйлдэж, 518.0 мянган төгрөгийг төлүүлэх арга хэмжээ аваад байна.

Төсвийн болон төрийн өмчийн оролцоотой 40 байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 827.6 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж, 39.2% буюу 324.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Санхүүгийн шалгалтаар илэрч байгаа төлбөр зөрчлийн байдлыг авч үзэхэд:

- Төрийн өмчийн болон төсвийн хөрөнгийг үр ашиг багатай зүйлд зарцуулах
- Төрийн өмчийн болон төсвийн байгууллагад хөрөнгө мөнгийг данс бүртгэлд тусгалгүй орхигдуулах, өр авлагыг үндэслэлгүй хаах, бүрдэлгүй баримтаар гүйлгээ хийж, хөрөнгө зарцуулах зэргээр нягтлан бодох бүртгэлийн хууль, санхүүгийн сахилгыг зөрчсөн
- Шалгагдсан аж ахуйн нэгжүүд элдэв төрлийн татварыг төсөвт дутуу төлөх, ажиллагсдын цалин, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж авч төвлөрүүлээгүй зэрэг зөрчлүүд гарч байгаагийн зэрэгцээ Төсвийн эд хөрөнгө, машин техникийг зах зээлийн үнээс доогуур худалдах, өндөр үнээр бусдаас худалдан авах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэх, төрийн өмч, төсвийн хөрөнгөөр хандив өгөх, шагнал урамшууллыг хавтгайруулан олгох, төрийн өмч, төсвийн хөрөнгийг хувьдаа ашиглах оролдлого гарч байна.

2006 оны эхний 4 сард санхүүгийн шалгалтын явцад ногдуулсан нийт төлбөрөөс 236.8 сая төгрөгийг барагдуулж, 216.5 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт оруулсан.

“Махны хангамжийг тогтвортой байлгах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 211-р тогтоолын дагуу мал нядлах, мах боловсруулах үйлдвэрт бэлтгэгдсэн мах, махан бүтээгдэхүүний хадгалалтын үеийн МЭАЦ-ийн шаардлагын хэрэгжилтийн талаар шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар авах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

Ингэснээр улсын хүн амын талаас илүү хувь нь шахам амьдардаг нийслэлчүүдийн махны хангамж, аюулгүй байдлын баталгааг хангах, махны үнийн хөөрөгдлийг тогтоон барихад төрийн зүгээс үзүүлж байгаа нэгэн төрлийн үйлчилгээ болж байна.

ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН ЗАСГИЙН ГАЗРААС ОЙРЫН ХУГАЦААНД ХИЙХ АЖЛЫН ТАЛААР:

Төрийн удирдлага, иргэдийн оролцооны асуудлаар:

- ✓ Хөдөө орон нутгийн хөгжлийг хангахад чухал ач холбогдол бүхий “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”, “Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги” зэрэг хууль тогтоомжийн биелэлтийг эрчимжүүлэх болно.
- ✓ Орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах зорилтыг иш үндэс болгон “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай”, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай”, “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай”, “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” зэрэг холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахын зэрэгцээ энэ чиглэлээр бодит ажлыг зохион байгуулахад анхаарлаа хандуулна. Мөн энэ хүрээнд бүх шатны Хурал, Засаг даргын ажлын албыг бэхжүүлэх, Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын хоорондын харилцан уялдааг сайжруулахыг чухалчлан үзнэ.
- ✓ Хүн амын амьжиргааг дээшлүүлэх үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийн хуваарилалтыг боловсронгуй болгох замаар ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах, улмаар дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх нь чухал болохыг онцгойлон анхаарч байна.
- ✓ Засгийн газрын зүгээс ард түмнийхээ төлөө хийх бүтээх зарим үйл ажиллагаа тухайлбал, уул уурхай, ашигт малтмалын ашиглалт, эрчим хүч, жижиг, дунд үйлдвэр, малчид, иргэдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг, газар тариалан хөгжүүлэх, говийн аймгуудын усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллана. .
- ✓ Орон нутгийн бие даасан байдлыг хангах, төсөв, санхүүгийн болон боловсон хүчний асуудлаар орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчид намын гишүүнчлэлгүй байх тухай саналыг судалж Улсын Их Хурлын Түр хороотой хамтран ажиллана.

Нийгмийн бодлогын талаар:

- ✓ “Боловсролд чанарыг, соёл, урлагт хүртээмж, ур чадварыг, шинжлэх ухаанд үр дүнг эрхэмлэе” гэсэн эрмэлзэлийг дэвшүүлэн ажиллана.
- ✓ “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хүрээнд 15-аас дээш насны хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэгийг ирэх 6 дугаар сараас зохион байгуулна.
- ✓ Мянганы сорилтын сангийн тусламжтайгаар “Эрүүл мэндийн байгууллагуудын оношлогооны чадавхийг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлнэ.
- ✓ Улаанбаатар хотод “Оношлогоо, эмчилгээний төв”, “Яаралтай тусламжийн төв”-ийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
- ✓ Үндэсний спортын 3 дугаар их наадмыг орон даяар зохион байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ 2006 онд Монгол Улсад оюутны дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бөх, Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах зуун буудалт даам, Зүүн Азийн аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнүүдийг зохион байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлнэ.

- ✓ Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй гэрээт ажилтнуудын цалинг 2006 онд нэмэгдүүлэх тухай асуудлыг төсвийн бодлогын хүрээнд шийдвэрлэхээр ажиллана.
- ✓ “Албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлыг оны сүүлийн хагасаас эхлүүлнэ.
- ✓ Тэтгэврийн зөрүү гэсэн асуудлыг бүрэн шийдвэрлэх үүднээс хууль эрх зүйн зохицуулалт бий болгох асуудлыг шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн хамт боловсруулж, 2006 оны төсвийн тодотголд тусгуулаад байна. Түүнчлэн нэгдэлжих хөдөлгөөнд хамрагдаж, АИХ-ын 1979 оны 14 дүгээр зарлигаар ХАА-н нэгдлийн гишүүний хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгон авч байгаа 1.5 мянган хүний тэтгэврийн хэмжээг Нийгмийн даатгалын тухай хуулинд заасан бүрэн тэтгэврийн доод хэмжээнд хамааруулан, 2006 оны 7 дугаар сарын 1-нээс олгоход шаардагдах 120.6 сая төгрөгийн эх үүсвэрийг 2006 оны оны төсвийн тодотголын төсөлд суулгаж хэрэгжилтийг зохион байгуулна.

Эдийн засгийн бодлогын талаар

- ✓ 2007 оны төсвийн хүрээний мэдэгдлийг өргөн бариад байна. Засгийн газар дунд хугацаанд буюу 2007-2009 онд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээг 1066 ам.долларт буюу 1.4 сая төгрөгт хүргэх, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх, эрчим хүчний хомсдол бүхий айл өрхийн тоог эрс цөөлөх, ХАА-г эрчимжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, хүнд суртал авилгатай тэмцэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийн хуваарилалтыг оновчтой болгох зэрэг томоохон зорилтыг дэвшүүлэн тавьж байна.
- ✓ Эрдэнэт хотод “Үйлдвэр технологийн парк”, Говьсүмбэр аймагт “Алтан говь хөгжлийн парк” байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлууд багтах болно.
- ✓ Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлж, ажлын 50 мянган байр шинээр бий болгох, үүний тулд ХАА, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний зэрэг ажлын байр шинээр нэмэгдэж буй салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг тогтмол хийж, сум орон нутагт буй нөөцийг үндэслэн үйл ажиллагаагаа явуулахад зориулж Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөрөөс 1.5 сая ам долларын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулж, орон нутгийн мэдэлд шилжих “Мэргэжлийн боловсрол, сургалтын дэд бүтэц”-ийг орон нутгийн бодлоготой уялдуулан ашиглах, аймаг, нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжин явуулж буй мэргэжлийн сургалт, ажилд зуучлах, нийтийг хамарсан ажлын үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх бодлого баримталж байна.
- ✓ Хөнгөн үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлэх концепцийн хүрээнд арьс ширний үйлдвэрлэл, ноос ноолуурын үйлдвэрийн салбарын цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ. Энэ төслийн хүрээнд эцсийн бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйлдвэрүүдийг Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Багануур хотод байрлуулж, 7000 ажлын байр бий болгох ажлыг эхлүүлэх болно. Дотоодын ээрмэлийн түүхий эд дээр тулгуурласан сүлжмэлийн үйлдвэрүүдийг Дархан, Эрдэнэт, Хөтөл, Багануур, Улаанбаатар хотуудад байгуулах төслийг эхлүүлнэ.
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн эрх зүйн байдлын тухай хуулийг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэн, УИХ-д өргөн барина. Жижиг, дунд үйлдвэрийг тоног төхөөрөмжөөр хангах боломж бүрдүүлэх зорилгоор Лизингийн тухай хуулийг хэлэлцүүлж өргөн барина.
- ✓ Уул уурхайн салбарт улсын төсвөөр хийгдсэн хөгжлийн, стратегийн ач холбогдолтой ордуудын лиценз эзэмшигчидтэй хийх гэрээ, хэлэлцээрийн удирдамжийг боловсруулж, яриа хэлэлцээг эхлүүлнэ.
 1. Оюу толгойн ордын хөрөнгө оруулагчтай хэлэлцээг эхлүүлнэ.
 2. Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийг түшиглүүлэн хар металл боловсруулах цогцолборын төслийн ажлыг эхлүүлнэ. Төмөртэй, Хустай зэрэг ордын лиценз эзэмшигчидтэй хэлэлцээ хийх.

Бүс нутаг, хот байгуулалт, хөдөөгийн бодлогын талаар

- ✓ Хүн амыг орон сууцаар хангах, барилгын салбарт ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөрийг УИХ-аар батлуулна.
- ✓ Орон сууцны зориулалттай урт хугацааны зээлийн тогтолцоог бий болгоно
- ✓ Герман Улсын тусламжаар 2006-2014 онд 2 үе шатаар хэрэгжих “Хотын иж бүрэн үнэлгээ ба барилгын үйлдвэрлэлийг дэмжих” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Яармагийн орчинд орон сууцны хороолол барих судалгаа, төлөвлөлийн ажлыг эхлүүлнэ.
- ✓ Хот байгуулалтын тухай болон Хот тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулиудыг шинэчилсэн хуулийн төслүүдийг боловсруулж УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлнэ.
- ✓ Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөг шинэчлэх болон манай улсын томоохон хотуудын орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлнэ.
- ✓ Хот төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын жишигт нийцсэн 6-8 норм дүрэм стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулж мөрдүүлнэ.
- ✓ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, төрийн дэмжлэгийг төвлөрүүлж усалгаатай тариалангийн талбайн хэмжээг өмнөх оноос 7.5 хувиар нэмэгдүүлж, цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоог 5.5 хувиар өсгөж үүний дотор шилдэг омог, үүлдрийн малын цөм сүргийн тоог 918 мянгад хүргэж, бага оврын техник хангамжийг 25-30 хувиар, фермерийн аж ахуйн тоог 32 хувиар нэмэгдүүлнэ.
- ✓ Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарч таримал тэжээл үйлдвэрлэлийг 12 хувиар, байгалийн хадлан бэлтгэлийг 7.5 хувиар тус тус нэмэгдүүлж царгас, хошоон зэрэг уургийн агуулалмж өндөртэй тэжээлээр улсын нөөцийн зарим хэсгийг бүрдүүлэх арга хэмжээ авна.
- ✓ Малын халдварт паразит өвчнөөс сэргийлэх эмчлэх ажлын чанарыг сайжруулж, 21.8 сая толгой малыг халдварт өвчнөөс, 7.3 сая толгой малыг паразит өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 3.0 сая толгой малыг шүлхийн вакцинжуулалтад тус тус хамруулна.
- ✓ Эрүүл ахуйн шаардлага хангасан дотоодын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүн амын хүнсний хангамжийг өнгөрсөн оноос 7-9 хувиар нэмэгдүүлнэ.
- ✓ Энэ оныг газар тариалангийн техник, технологийн шинэчлэлийн жил болгон зарлаж байгаатай уялдуулан “Тариалан эрхлэх технологийн үлгэрчилсэн зөвлөмж”-ийг үндэслэн аймаг, сум, аж ахуйн нэгж бүр өөр өөрийн хөрс, цаг уурын онцлогт нийцсэн тариалан эрхлэх технологийг шинэчлэн боловсруулж мөрдөнө.
- ✓ Дотоодын бүтээгдэхүүнээр үйлдвэрлэх гурилын хангамжийг нийт хэрэгцээний 25 хувьд, төмс, хүнсний ногооны хангамжийг 54.4 хувьд хүргэж үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг өмнөх оноос 10 хувиар, махны хэмжээг 7.9 хувиар тус тус нэмэгдүүлнэ.
- ✓ Бэлчээр усжуулалт, усалгаатай тариаланг сэргээн хөгжүүлэхэд онцгой анхаарч улсын төсөв болон гадаадын зээл тусламжаас хуваарилсан хөрөнгийг үр ашигтай ашиглан 750 худгийг засч, 200 худаг шинээр гаргах, 250 мянган га-гаас доошгүй талбайд үлийн цагаан оготнотой, 70.0 мянгаас доошгүй га-д хөнөөлт царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулж эдгээр ажлын явцад хяналт тавьж ажиллана.
- ✓ Бод малыг ээмэг, тамгатай болгох санаачилгыг бүх аймаг, сум, малчдын дунд өрнүүлнэ.
- ✓ Шинжлэх ухаан, технологийн төслүүдийг захиалах, хэрэгжүүлэх болон түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлын уялдаа, хариуцлагыг сайжруулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- ✓ Төвийн болон баруун бүсийн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний нөөцөд тулгуурласан дотоодын эх үүсвэр бий болгох, импортын эрчим хүчний хараат байдлаас гарах зорилтын хүрээнд 100-220 МВт-аас доошгүй хүчин чадал бүхий Орхон, Эгийн голын УЦС-ыг барих ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.
- ✓ Тайширын УЦС-ыг 2008 онд ашиглалтад оруулж, Говь-Алтай, Завхан аймгийн төвтэй холбож, ойролцоох сумдын төвийг холбосон сүлжээ бий болгож, улмаар Тайширын УЦС-ыг Баруун бүсийн эрчим хүчний системтэй холбохоор төлөвлөж

байна. Мөн Хөвсгөлийн Чаргайтын УЦС барих ажлын судалгааг эхлүүлэх арга хэмжээ авна.

- ✓ Төвлөрсөн эрчим хүчинд холбогдоогүй 100 гаруй сум, суурин газрыг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох болон сэргээгдэх эрчим хүч, нүүрсний хийн цахилгаан станц барьж цахилгаан хангамжийг нь шийдвэрлэхээр төлөвлөж байна.
- ✓ “100 000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлээд байгаа ба ингэснээр 2006 онд 50 мянга, 2007 онд 50 мянга, 2008 онд 20 мянган малчин өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангах арга хэмжээг авах болно.
- ✓ Говийн бүс нутгийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой Тавантолгой, Оюу толгой, Цагаансуварга болон бусад томоохон ордыг ашиглахад шаардагдах эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээр хангахын тулд Улаанбаатар - Мандалговь - Оюутолгойн чиглэлд 220 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг барих судалгааны ажлыг 2006 онд багтаан хийнэ.
- ✓ Нялга - Чойрын сав газрын нүүрсний ордыг түшиглэн томоохон чадлын эрчим хүчний эх үүсвэр барих, улмаар цахилгаан эрчим хүчийг БНХАУ-д экспортлох талаархи тооцоо, судалгааг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээг авна.
- ✓ Шингэрүүлсэн шатдаг хийн ажил, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлнэ.
- ✓ Тавантолгой, Багануур, Шивээ овоо, Нарийн сухайт, Элдэв, Улаан-Овоо зэрэг нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар жилд 2.0-5.0 сая тонноос доошгүй нүүрс экспортлох чиглэлийг баримталж байна. Мөн Тавантолгойн коксжих нүүрсний орд газарт эрчим хүч, кокс-химийн цогцолбор барих бодлого, чиглэлийг тодорхойлж олон талын оролцоотойгоор шийдвэрлэх арга хэмжээ авна.

Байгаль орчны бодлогын талаар

- ✓ Монгол Улсын Ойн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж батлуулан хэрэгжүүлж эхэлнэ.
- ✓ Био аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барина.
- ✓ Хөвсгөл аймгийн Уйлган голын сав газар, Хорьдол Сарьдагийн нурууны өргөтгөл, Увс аймгийн Баяннуур-Урт булаг, Гooжуурын хүрхрээ, Баянзүрх уул, Дорнод, Сүхбаатар аймгийн Хэрлэн Мэнэн, Жаран тогоон тал, Баянхонгор аймгийн Заг Байдрагийн хүрэн Бэлчир зэрэг газруудыг улсын тусгай хамгаалалтанд авах асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллана.

Батлан хамгаалах, гадаад бодлогын талаар:

- ✓ Батлан хамгаалах тухай болон Зэвсэгт хүчний тухай багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Орон нутгийн хамгаалалтын үзэл баримтлал”-ын төсөл, Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталгаажуулан хэрэ.
- ✓ Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсронгуй болгох үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- ✓ Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан гэрээт цэргийн алба хаах журам болон иргэн цэргийн алба хаахтай холбогдсон бусад журмуудыг шинэчлэн боловсруулна.
- ✓ Ашиглалтын хугацаа нь дуусч, үндсэн хөрөнгийн данснаас хасагдсан болон манай зэвсэглэлд ашиглах шаардлагагүй зэвсэглэл техникийн асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө төвлөрүүлэх замаар зэвсэглэл техникийн тодорхой хэсгийг шинэчлэх,
- ✓ Энэ онд ОХУ-д хийх Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГХК-ын ээлжит хуралдаан болон тус комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын хуралдааныг ойрын хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү айлчлал нь шинэ зуунд хоёр орны уламжлалт түншлэлийн харилцааг улам өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Хууль хяналтын байгууллагыг бэхжүүлэх бодлогын талаар

- ✓ Орон нутгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилд тус дөхөм болох үүднээс энэ онд “Эрх зүйн туслалцааны төв”-ийг байгуулахаар төлөвлөж байна.
- ✓ Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал төр, захиргаа, хууль хяналтын байгууллагын анхаарал татсан асуудал хэвээр байна. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль 2004 оноос мөрдөгдөж эхэлсэн ба уг хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх болно.
- ✓ Иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж, цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг ойртуулах, түргэн шуурхай болгох ажлын хүрээнд гэр хороолол, орон сууц, гудамж талбайд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, орон нутгийн цагдаагийн хэсгийн төлөөлөгч, байцаагч нарын ажлын ачаалал, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ зэргийг харгалзан хүн амын нягтрал их, өмч хөрөнгө төвлөрсөн, гэмт хэрэг, зөрчил олноор гарч байгаа цэгүүдэд Японы цагдаагийн байгууллагын туршлагаар “Кобан”-ы байрыг барьж байгуулах ажлыг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.
- ✓ Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн бүртгэл, хяналтыг сайжруулах, улсын хилээр нэвтэрсэн, тус улсад зорчиж буй болон дамжин өнгөрч буй гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөний талаарх бүртгэл, судалгааг холбогдох орон нутгийн байгууллагуудтайгаа хамтран цэгцлэж, байнгын хяналт тавьж ажиллана.
- ✓ Монгол Улсад гэрээгээр ажиллаж буй зарим орны гадаад иргэдийн бүртгэл, визний хугацаа, түүнд тавих хяналтын асуудлыг зохион байгуулж, тэдгээр иргэдийг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдэд тавих хяналт, шалгалтаа тогтмолжуулан хариуцлага тооцож ажиллана.
- ✓ 2006 онд улсын хэмжээнд Иргэний баримт бичгийн улсын үзлэгийг зохион байгуулахаар төлөвлөж байна.
- ✓ Төрийн үйлчилгээг анхан шатанд ард иргэдэд хүртээмжтэй, шуурхай зохион байгуулан явуулах нь онц чухал бөгөөд энэ талаар Хэнтий аймгийн Бор-Өндөр тосгоны төрийн үйлчилгээний цогцолбор барилга барих хөрөнгийн асуудлыг бусад байгууллагатай хамтран шийдвэрлэх талаар ажиллах ба гал унтраах ангийг сэргээн ажиллуулахад шаардагдах урсгал зардлыг 2007 оны төсөвт тусгахаар төлөвлөж байна.
- ✓ Орон нутагт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг илүү шуурхай болгох шаардлагын үүднээс түүний техник хангамжийг сайжруулахад 2006 онд 210.0 сая төгрөг баталсан нь 2005 онтой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн юм. Цаашид уг асуудлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгах замаар шийдвэрлэхэд анхаарах ба Завхан аймгийн Тосонцэнгэл дэх сум дундын цагдаагийн тасагт суудлын автомашин олгосны гадна Говьсүмбэр аймгийн цагдаагийн ажилтнуудын орон сууцны хангалтад зориулж 40.0 сая төгрөг олгох асуудлыг төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.
- ✓ Хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах нь ард иргэдийн амьжиргаанд ихээхэн тустайг анхаарч ажиллаж байгаагийн дотор Өмнөговь аймгийн Гашуунсухайтын хилийн боомтыг энэ оны III улиралд багтаан байнгын ажиллагаатай болгох арга хэмжээ авна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР